# НИЙГМИЙН ТУХАЙ МЭДЛЭГ

# 2010

## ХУВИЛБАР А

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Нийгэм төрөл бүрийн элементээс тогтох бөгөөд тэр элемент нь бас бүтэцлэг шинжтэй, өөрийн үнэт чанар, хэм хэмжээ, үүрэгтэй гэж үздэг Бүтэц үүргийн онолын төлөөлөгчдийг нэрлэнэ үү. (1 оноо)
   A. В.Парето, Г.Моска
   B. К.Маркс, Ф.Энгельс
   C. Т.Парсонс, Р.Мертон
   D. О.Шпенглер, Ж.Тойнби
   E. Г.Лебо, Г.Тард
2. Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн дараах үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ.Үндсэн үүрэгт холбогдолгүй өгөгдлийг олно уу. (2 оноо)
   A. Хуулиар ноогдуулсан албан татвар төлөх
   B. Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж сахин биелүүлэх
   C. Эрүүл мэндээ хамгаалж зөв шударга хөдөлмөрлөх
   D. Хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх
   E. Эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах
3. Нийгмийг зөвхөн нийгмийн хүчин зүйлсээр тайлбарлах бөгөөд нийгмийн үйл явцад байгалийн хүчин зүйлс бараг үүрэггүй гэж үздэг онол байдаг. Энэ онолын төлөөлөгчдөөс В.Парето, Г.Моска нар доорх өгөгдлийн аль үзлийг баримтлагчид вэ? (1 оноо)
   A. Сэтгэл зүйн сургаалтнууд
   B. Элитийн онол
   C. Эдийн засгийн онолтнууд
   D. Бүтэц, үүргийн онол
   E. Иргэншлийн онол
4. Анх социологи хэмээх нэр томъёог хэрэглэн, нийгмийг шинжлэх ухааны үүднээс судлах зорилгыг хэн дэвшүүлсэн бэ? (1 оноо)
   A. Ж. Руссо B. О. Конт C. Платон D. Т. Гоббс E. Ж. Локк
5. Иргэний нийгмийн тухай үзэл санааг хамгийн анх дэвшүүлж тавьсан сэтгэгчид хэн бэ? (1 оноо)
   A. Н.Макиавелли, Ж.Локк
   B. Платон, Аристотель
   C. Ш.Л.Монтеське, М.Вебер
   D. И.Кант, Г.Гегель
   E. Эдгээрээс өөр
6. Хүмүүс нь мах цусан төрлийн холбоогоор холбогдсон, нийгэм нь овгийн зохион байгуулалттай төргүй, өмчийн ялгаа гараагүй нийгэм 50,000-40,000 жилийн өмнө үүсчээ. Энэ нийгэм бол …………… (1 оноо)
   A. Агнуурын болон түүвэрлэгчдийн нийгэм
   B. Нийлмэл нийгэм
   C.Энгийн тариалангийн нийгэм
   D. Газар тариалангийн нийгэм
   E. Энгийн нийгэм
7. Нийгмийн хөгжлийг байгалийн хүчин зүйлээр тайлбарладаг бөгөөд тухайн улс үндэсний хөгжилд уур амьсгал, хөрс, усан мандал чухал үүрэгтэй гэж үздэг онол бий. Энэ онолын төлөөлөгч Л.Н.Гумилев, Г.Гегель, Ш.Л.Монтеське нар доорх өгөгдлийн аль үзлийн төлөөлөгчид вэ? (1оноо)
   A. Газар зүйн үзэлтнүүд
   B. Биологийн сургаалтнууд
   C. Хүн ам зүйн сургаалтнууд
   D. Бүтэц үүргийн онолтнууд
   E. Иргэншлийн онолтнууд
8. Нийгмийн амьдралын хүрээг зохих өгөгдөлтэй нь зөв холбоно уу. (5 оноо)

| | |
|---|---|
| 1. Улс төрийн хүрээ | A. Багануурын уурхай нүүрсээ IV цахилгаан станцад нийлүүлж оронд нь цахилгаан авч хэрэглэдэг |
| 2. Эдийн засгийн хүрээ | B. Сурагч бүхэн улсын иргэний хувьд улс төрийн шийдвэр, төрийн хууль, журмыг дагаж мөрддөг, биелүүлдэг иргэн болж төлөвших учиртай |
| 3. Социал (нийгмийн) хүрээ | C. Б.Ренчин доктор “Чихнээ чимэг болсон яруу сайхан монгол хэл” хэмээн эх хэлээ магтан дуулсан байдаг |
| 4. Оюун санааны хүрээ | D. “Бусдын хэрэг бүтвэл, өөрийн хэрэг бүтнэ” гэсэн Монгол ёсыг дагаж бусадтай харилцах, бусадтай хамтран ажиллах зэргээр харилцааны соёлд суралцах нь сайн хүн болохын нэг шинж мөн |
| 5. Иргэний нийгэм | E. Төрөөс хамааралгүй үүсээд улмаар төрөөс хууль ёсоор зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа явуулда янз бүрийн байгууллага ба зохион байгуулалт юм |

   A. 1C2E3D4B5A
   B. 1D2B3A4E5C
   C. 1E2D3C4B5A
   D. 1B2A3D4C5E
   E. 1B2A3E4C5D

9. Нийгмийн хөгжилд хүн амын тоо, хүнс тэжээлийн нөөц чухал үүрэгтэй гэж үзсэн эрдэмтнийг нэрлэнэ үү. (1 оноо)
   A. Л.Н.Гумилев B. Т.Мальтус C. Г.Спенсер
   D. Демокрит E. У.Беджгот
10. Моногами, полигами, полигани, полиандри гэсэн ойлголтуудыг нэгтгээд юу гэж нэрлэдэг вэ? (1 оноо)
   A. Гэр бүлийн үүргүүд B. Гэр бүлийн хэлбэрүүд
   C. Гэр бүлийн оршин тогтнох үндэсүүд D. Гэр бүлийн бүтэц
   E. Гэрлэлтийн хэв маягууд
11. Германы эрдэмтэн Макс Вебер нийгмийн давхраажилтын 3 хэмжигдэхүүнийг анх тодорхойлсон. Орчин үед 4 дэх хэмжигдэхүүнийг нэрлэж байгаа нь аль вэ? (1 оноо)
   A. Эд баялаг B. Боловсрол C. Мэдлэг
   D. Нэр хүнд E. Эрх мэдэл
12. Үндсэн элемент нь хүмүүс, тэдгээрийн харилцан холбоо, харилцан үйлчлэл болдог байгууламжийг социологийн ухаанд юу гэж нэрлэдэг вэ? (1 оноо)
   A. Нийгмийн холбоо хамаарал B. Нийгмийн харилцан үйлчлэл
   C. Нийгмийн тогтолцоо D. Нийгмийн харилцаа
   E. Нийгмийн нөхцөл
13. Социологи нь "эв нэгдэл, зөвшилцөл" тогтооход тус дөхөм үзүүлэх үүрэгтэй гэсэн үзэл хэнийх вэ? (1 оноо)
   A. Р.Мертон B. О.Конт C. Э.Дюркгейм
   D. М.Вебер E. Г.Спенсер
14. Нийгмийн институтуудын цогцыг юу гэж нэрлэдэг вэ? (1 оноо)
   A. Нийгмийн практик B. Нийгмийн үүрэг C. Нийгмийн систем
   D. Нийгэм E. Нийгмийн институц
15. Ядууралд бусдаас илүү өртөх магадлалтай нийгмийн бүлгүүдийг хууль тогтоомжинд . ………... гэж нэрлэдэг. Аль нь вэ? (1 оноо)
   A. Нийгмийн эмзэг бүлэг B. Нийгмийн хамгаалал C. Нийгмээр халамжлуулдаг хэсэг
   D. Ядуу амьдралтай хүмүүс E. Бие дааж амьдрах чадваргүй хүн
16. Хувь хүн гэсэн хийсвэр ойлголтонд үл хамаарагдах өгөгдлийг олно уу. (1 оноо)
   A. Индивид (individ) – хуваагдашгүй, эцсийн гэсэн латин үг
   B. Анхдагч, тусгай, тодорхой хүнийг тэмдэглэнэ
   C. Тухайн хүний сэтгэц, ухамсар, авир араншин, зан төлөв нь бусад хүнтэй харьцуулахад давтагдашгүй өвөрмөц
   D. Нийгмийн харилцаанд бие даан оролцож, нийгэмд тодорхой байр суурь эзэлсэн нийгмийн үнэт чанарыг эзэмшсэн хувь хүн
   E. Бие хүн төлөвших эхний шат
17. Ардчиллын үндсэн шинж, зарчмуудад аль нь үл тохирох вэ? (1 оноо)
   A. Тэгш эрх B. Хуулинд захирагдах ёс C. Хүний эрх, эрх чөлөө
   D. Нэг намын тогтолцоо E. Иргэдийн улс төрийн оролцоо
18. Системийн шинжилгээний аргыг улс төрийн ухаанд анх хэрэглэж энэ үндсэн дээр улс төрийн системийн онолын загварыг боловсруулсан улс төр судлаачийг нэрлэнэ үү. (1 оноо)
   A. В.Пауэлл B. Д.Истон C. Г.Алмонд
   D. Г.Лассвелл E. Ш.Л.Монтеське
19. Орчин үед фашизм, нацизм, Сталины коммунизмыг доорх ангиллын алинд нь сонгодог жишээ болгодог вэ? (1 оноо)
   A. Тоталитаризм B. Авторитаризм C. Ардчилал
   D. Либерал ардчилсан E. Ардчилсан бус
20. Засгийн эрхийн төлөө эрмэлзэж улс төрийн үйл ажиллагаа явуулдаг, зохион байгуулалттай нийгмийн институтыг . . . гэнэ. Зөв хариуг өгөгдлөөс олно уу. (1 оноо)
   A. Сонирхлын бүлэг B. Улс төрийн нам C. Төрийн бус байгууллага
   D. Эвсэл, хөдөлгөөн E. Олон нийтийн байгууллага
21. Монгол улсын төрийн хүндэтгэлийн бэлгэдэл аль нь вэ? (1 оноо)
   A. Төрийн сүлд B. Төрийн Их цагаан туг C. Төрийн далбаа
   D. Төрийн дуулал E. Төрийн тамга
22. Монголчуудын "Төрийн минь сүлд өршөө" гэж залбиран төрөө дээдлэх явдал нь аль легитим шинжийг илэрхийлж байна вэ? (1 оноо)
   A. Харизмат B. Хууль ёсны C. Үзэл суртлын
   D. Уламжлалт E. Ангийн

23. Монгол Улсын Засгийн газрын эрх мэдэлд үл хамаарах өгөгдлийг тодорхойлно уу. (1 оноо)
    A. Хуулийн биелэлтийг хангах
    B. Байгаль орчныг хамгаалах
    C. Үндэсний аюулгүй байдлыг хангах
    D. Хуульд хориг тавих
    E. Төрийн гадаад бодлогыг хэрэгжүүлэх
24. УИХ-ын онцгой бүрэн эрхэд заагаагүй буруу өгөгдлийг олно уу. (1 оноо)
    A. Хууль батлах, нэмэлт өөрчлөлт оруулах
    B. Төрийн дотоод гадаад бодлогын үндсийг тодорхойлох
    C. Батлагдсан хууль, УИХ-ын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах
    D. Уучлал үзүүлэх
    E. Ард нийтийн санал асуулга явуулах
25. Бүх нийтийн, чөлөөтэй, шууд, нууц, тэгш эрх зэрэг нь аль өгөгдөлд хамааралтай вэ? (1 оноо)
    A. Сонгуулийн систем
    B. Сонгуулийн зарчим
    C. Төлөөллийн ардчилал
    D. Ардчилсан сонгууль
    E. Иргэдийн оролцооны хэлбэр
26. Тоталитар дэглэмийн үндсэн шинжүүдийг тохируулна уу. (4 оноо)

| | |
|---|---|
| A. Нэг үзэл суртал | 1. Тухайн улс орны хэмжээнд ганц намын тогтолцоонд үйлчилсэн, улс төржсөн ҮЭ, залуучуудын болон хүүхдийн байгууллага оршихыг зөвшөөрдөг. Мөн хянах, албадах үүрэгтэй тогтолцоо оршино |
| B. Улс төрийн систем | 2. Бүх өмчийг нийгэмчилж, амины өмчийг зөвшөөрдөг ч хувьдаа бусдаас илүү зүйлтэй байхыг үл зөвшөөрнө. Чөлөөт өрсөлдөөний тухай ойлголт байхгүй |
| C. Нийгмийн бүтэц | 3. Сурагчид пионерийн гишүүнд элсэхдээ “Марксизм, Ленинизм, Пролетарийн интернационализм”-д үнэнч байхаа тангарладаг. Нийгмийн хичээлээр Марксизм, Ленинизмийн онолыг номлодог байв. Номлолыг зөрчвөл “дайсан” болно |
| D. Эдийн засаг | 4. Хувь хүн төрийн бүх талын хяналтанд, бүрэн хараат байдалд оршино. Монгол улсын ажилчин анги нийгмийн манлайлагч хүч болдог. “Орон бүхний пролетари нар нэгдэгтүн” уриан дор ажилчин ангийг бусад ангиас дээгүүр үзнэ |

    A. A3B1C4D2
    B. A2B4C3D1
    C. A1B4C3D2
    D. A4B1C3D2
    E. A1B2C4D3
27. “Хүн бүрийн өөрийн эрх ашгийг хангасан үйл ажиллагаа нь эцэстээ нийгмийн баялагийг бүтээгч болдог”-ийг эдийн засгийн ямар онол тодорхойлсон байдаг вэ? (1 оноо)
    A. Шинэ сонгодог онол
    B. Сонгодог эдийн засгийн онол
    C. Меркантализм
    D. Кейнсизм
    E. Монетаризм
28. Бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулсан түүхий эд материалыг ямар зардалд оруулж тооцох вэ? (2 оноо)
    A. Шууд зардал
    B. Тогтмол зардал
    C. Хувьсах зардал
    D. A ба B
    E. A ба C
29. Аж ахуйн нэгж байгууллага ашгаа тодорхойлж төлсөн татвар нь (2 оноо)
    A. Төлбөр
    B. Шууд бус татвар
    C. Хураамж
    D. Албан татвар
    E. Шимтгэл
30. Үйлдвэрт шинэ техник технологи нэвтрүүлэхэд үүсэх ажилгүйдэл.
    A. Мөчлөгийн ажилгүйдэл
    B. Үйлдвэрийн ажилгүйдэл
    C. Бүтцийн ажилгүйдэл
    D. Завсрын ажилгүйдэл
    E. Хүлээлтийн ажилгүйдэл
31. Бараа үйлчилгээний нийт хэмжээг түүний үнээр үржүүлж, мөнгөний эргэлтийн тоонд харьцуулсан нь эдийн засгийн ямар үзүүлэлтийг тодорхойлох вэ? (1 оноо)
    A. Хэрэглээний барааны үнийн индекс
    B. Гүйлгээнд байгаа мөнгөний тоо
    C. Тэнцвэрт үнэ
    D. Банкинд байгаа мөнгөний дүн
    E. Зах зээлийн үнэ
32. Та бараа, үйлчилгээ худалдан авахдаа төлсөн нэмэгдсэн өртгийн татвар нь... (2 оноо)
    A. Төлбөр
    B. Шууд бус татвар
    C. Хураамж
    D. Шууд татвар
    E. Шимтгэл
33. Эдийн засгийн хямралын үед үүсэх ажилгүйдэл ….. (2 оноо)
    A. Мөчлөгийн ажилгүйдэл
    B. Үйлдвэрийн ажилгүйдэл
    C. Бүтцийн ажилгүйдэл
    D. Завсрын ажилгүйдэл
    E. Хүлээлтийн ажилгүйдэл

34. Тухайн улсын зөвхөн нэг жилд үйлдвэрлэн бий болгосон материал баялгийн хэмжээг . …………… . гэнэ. (2 оноо)
    A. Дотоодын нийт бүтээгдэхүүн B. Үндэсний цэвэр бүтээгдэхүүн
    C. Үндэсний орлого D. Үндэсний нийт бүтээгдэхүүн
    E. Дотоодын цэвэр бүтээгдэхүүн
35. Ажилгүйдлийн түвшин гэдэг нь... (2 оноо)
    A. Хөдөлмөрийн чадвартай хүн амын хэдэн хувь нь ажил эрхэлж байгааг илэрхийлнэ
    B. Нийт хүн амын хэдэн хувь нь ажил эрхлэхгүй байгааг илэрхийлнэ
    C. Хөдөлмөрийн чадвартай хүн амын хэдэн хувь нь ажил хайж хөдөлмөрийн биржид бүртгэлтэй байгааг илэрхийлнэ
    D. Хөдөлмөрийн чадвартай хүн амын хэдэн хувь нь ажил эрхлэхгүй байгааг илэрхийлнэ
    E. Нийт хүн амын хэдэн хувь нь ажил хайж хөдөлмөрийн биржид бүртгэлтэй байгааг илэрхийлнэ
36. Бага зардлаар бүтээгдэхүүн үйлдвэрлэж, түүнийгээ хурдан хугацаанд борлуулж чадсан нь ашиг олж, цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломжтой болно. Ингэж чадаагүй нь дампуурч зах зээлээс гарах хууль үйлчилнэ. Үүнийг шалгарлын хууль гэх ба эдийн засгийн ямар ойлголтоор дамжин хэрэгжих вэ? (2 оноо)
    A. Эрэлт, нийлүүлэлт B. Ажилгүйдэл C. Үл үзэгдэгч гар
    D. Өрсөлдөөн E. Инфляци
37. “Төр бол хамгийн муу менежер” гэсэн нь ямар утгыг илэрхийлж байгаа вэ? (2 оноо)
    A. Төр нь эдийн засгийн амьдралд гүйцэтгэх үүргээ биелүүлдэггүй
    B. Эдийн засгийн амьдралд төрийн оролцоо шаардлагагүй
    C. Төр бол менежер биш
    D. Төрийн оролцоотой бизнесийн үйл ажиллагаа төдийлөн амжилттай байдаггүй
    E. Дээрх тодорхойлолтууд бүгд буруу
38. Хөдөлмөрийн зах зээл дээр дээд боловсролтой мэргэжилтнүүд олноор бэлтгэгдэж гарч байгаа ч мэргэжлээрээ ажиллахгүй байгаагийн шалтгаан юу вэ? (2 оноо)
    A. Хөдөлмөрийн зах зээл дээрх нийлүүлэлт эрэлтээсээ давж илүүдэл үүссэн
    B. Хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлт нийлүүлэлтээсээ давж илүүдэл үүссэн
    C. Хөдөлмөрийн зах зээл дээрх нийлүүлэлт эрэлтээсээ давж хомсдол үүссэн
    D. Хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлт нийлүүлэлтээсээ давж хомсдол үүссэн
    E. Зөв хариулт алга байна
39. Монгол улс дахь шатахуун импортлодог компаниуд шатахууны үнийг нэмэхээр тохиролцож буй нь ямар өрсөлдөөнт зах зээлийг илэрхийлэх вэ? (2 оноо)
    A. Төгс өрсөлдөөнт B. Олигополь C. Монопольт өрсөлдөөнт
    D. Өрсөлдөөнт бус E. Монополь
40. ...................... гэдэг этноцентрист үзлийн эсрэг үзэл баримтлал бөгөөд аливаа соёл үнэхээр өвөрмөц онцлогтойг тунхагладаг үзэл юм. (1 оноо)
    A. Этноцентризм B. Релятивизм C. Универсал
    D. Плюрализм E. Дуализм
41. Соёлыг бүрдүүлэгч элементүүдийг тоочихдоо түүнд тохирохгүй өгөгдөл байгааг олно уу. (1 оноо)
    A. Бэлгэ тэмдэг B. Хэл C. Итгэл үнэмшил
    D. Нийгэмшилт E. Үнэлэмж
42. “Өөрийн толгой дээрх эврийг харахгүй, бусдын толгой дээрх өвсийг харах”. Энэ нь соёлын аль элементийг илэрхийлж байна вэ? (1 оноо)
    A. Хэм хэмжээ B. Итгэл үнэмшил C. Атаархал
    D. Шүүмжлэл E. Ёс суртахуун
43. Эдүгээ соёлын тухай 500-аад тодорхойлолт бий гэдэг. Доорх тодорхойлолтуудаас аль нь нэгтгэгч (интеграл буюу синтетик) маягийн тодорхойлолт болохыг олно уу. (2 оноо)
    A. Соёл бол хүмүүний хүмүүнлэг чанар илрэн хэрэгжих түүхэн тасралтгүй үйл явц, түүний үр дүн
    B. Хүнтэй хамт үүссэн нийгмийн үзэгдэл, арга, хэм хэмжээ, нийгмийн хяналт
    C. Соёл бол байгалийн зүйлсийг нийгмийн зүйлс болгодог, улмаар нэгэнт бүтээсэн нийгмийн зүйлсээ хүний үйл ажиллагааны бүх чиглэлээр улам боловсронгуй болгодог зохистой арга, хэм хэмжээ, нийгмийн хяналт
    D. Эдийн болон оюуны үнэт зүйлсийг бүтээж байгаа оюун ухаан
    E. Оюун ухаанаар бүтээгдсэн хоёр дахь байгаль, нийгмийн хяналт
44. Ураг төрлийн холбоогоо сайн мэдэх, ургийн бичиг хөтлөх нь соёлын аль элементийг илэрхийлж байна вэ? (1 оноо)
    A. Зуршил B. Заншил C. Уламжлал
    D. Нийтийн соёл E. Үнэлэмж

45. Аль бодомж нь зөв бэ? (1 оноо)
    A. Соёл бол нийгмийн үзэгдэл
    B. Соёл бол байгалийн үзэгдэл
    C. Соёл бол нийгэм, байгалийн аль алиных нь үзэгдэл
    D. Соёл бол нэг л үндэстний бахархал
    E. Соёл бол байгальд заримдаа тохиолдлын байдлаар харагдах үзэгдэл
46. Соёл шинэ үеийн хүмүүст мэдлэг туршлага олгоно. Энэ нь соёлын аль үүрэг вэ? (1 оноо)
    A. Мэдээллийн үүрэг B. Танин мэдэхүйн үүрэг C. Харилцааны үүрэг
    D. Төлөвшүүлэх үүрэг E. Хэм хэмжээний үүрэг
47. Аль бодомж буруу болохыг олно уу. (1 оноо)
    A. Хэл нийгмийн үзэгдэл B. Хэл соёлыг дамжуулах хэрэгсэл
    C. Хэл соёлыг залгамжлуулах хэрэгсэл D. Хэл соёлын үзэгдэл
    E. Хэл байгалийн үзэгдэл
48. Homosapiens үүссэн хугацааг сонгоно уу. (1 оноо)
    A. 50,000-40,000 жил B. 50,000-45,000 жил C. 30,000-20,000 жил
    D. 40,000-30,000 жил E. 60,000-50,000 жил
49. Оюуны соёлын байгууллагуудыг нэрлэхдээ буруу өгөгдөл оруулсныг нэрлэнэ үү. (1 оноо)
    A. Эрдэм шинжилгээний хүрээлэн B. Хүүхдийн зуслангийн байр
    C. Номын сан D. Театр
    E. Сургууль
50. Бүтээсэн эзэн нь тодорхой биш, авъяастнуудын бүтээсэн соёлыг юу гэж нэрлэдэг вэ? (1 оноо)
    A. Элитийн соёл B. Ардын соёл
    C. Зонхилогч соёл D. Дагуу соёл
    E. Нийтийн соёл
51. Нэн шинэ үеийн олон улсын харилцааг хэзээнээс эхэлсэн гэж судлаачид үздэг вэ? Зөв өгөгдлийг олно уу. (2 оноо)
    A. Дэлхийн I дайны дараах үеэс B. Дэлхийн II дайны дараах үеэс
    C. XX зууны эхэн үеэс D. 1991 оноос
    E. Эдгээрээс өөр
52. "Монгол улсын үндэсний эрх ашиг, аюулгүй байдлыг сахин хамгаалах үүднээс аль болох олон гүрэнтэй хамтын ажиллагаагаа өрнүүлж тэдний ашиг сонирхлыг Монголд бүрдүүлэхийг чиглэсэн бодлого байна" гэсэн зарчим аль нь вэ? (2 оноо)
    A. Олон тулгуурт B. Идэвхтэй
    C. Тэнцвэртэй D. Үндэсний эрх ашигт нийцсэн
    E. Эдгээрээс өөр
53. БНМАУ-ын Засгийн газар НҮБ-ын дүрмийг зөвшөөрч, түүний гишүүн болох хүсэлтээ анх 1946 оны 6-р сард гаргаснаасаа хойш 8 удаа илэрхийлсэн бөгөөд 15 жилийн дараа биелэлээ олжээ. Монгол улс НҮБ-д элссэн хугацааг өгөгдлөөс олно уу. (1 оноо)
    A. 1961 оны 10 дугаар сарын 25 B. 1961 оны 10 дугаар сарын 27
    C. 1962 оны 10 дугаар сарын 25 D. 1962 оны 10 дугаар сарын 27
    E. 1960 оны 10 дугаар сарын 10
54. Европын холбооны нэгдсэн мөнгөн тэмдэгтийг нэрлэнэ үү. (2 оноо)
    A. Доллар B. Марк C. Фунт стерлинг
    D. Франк E. Евро
55. 1961 онд Монгол Улс НҮБ-д элсэх хүртэл манай улсын зүгээс тус байгууллагад элсэхийг хүссэн өргөдөл удаа дараа өгч байсан боловч хойшлогдож байсны шалтгаан юу вэ? (2 оноо)
    A. Монгол улс НҮБ-ын гишүүн байх болзлыг хангаагүй
    B. Чан Кай Ши тэргүүтэй гоминдан намын байр сууръ
    C. Дипломатчдын үйл ажиллагаа сул байсан
    D. Дэлхийн улс орнууд дэмжихгүй байсан
    E. A ба C зөв
56. Дараах өгөгдлөөс буруу холбоосыг олно уу. (3 оноо)
    A. НҮБ 1945 онд АНУ-ын Сан Франциско хотод байгуулагдсан
    B. ЮНИСЕФ- НҮБ-ын Хүүхдийн сан
    C. UNFPA -НҮБ-ын Хүн амын сан
    D. Европын холбоо-НҮБ-ын байгууллага
    E. АНУ- Мянганы сорилын сан

57. Доорх өгөгдлүүдийн зөв харгалзааг сэргээнэ үү. (4 оноо)

| | |
|---|---|
| 1. Ерөнхий Ассамблей | A. НҮБ-ын бичиг хэргийг хариуцдаг. |
| 2. Аюулгүйн зөвлөл | B. НҮБ-ын энхийг сахиулах үүрэгтэй гол байгууллага. |
| 3. Олон улсын шүүх | C. Дэлхийн энх тайванд холбогдолтой бүхий л . асуудлаар хуралддаг |
| 4. Нарийн бичгийн дарга | D. Янз бүрийн улс хооронд дахь маргаантай нарын газар асуудлыг шийдвэрлэнэ. |

A. 1B2C3A4D B. 1D2C3A4B C. 1C2D3A4B
D.1B2D2A4C E. 1C2B3D4A

## ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу. (5 оноо)

| | |
|---|---|
| A. Хүмүүсийн улс төрийн үйл ажиллагааны зорилго, арга хэрэгсэлд нийгмийн зүгээс тавих шаардлагуудыг хэлнэ | 1. Нийцтэй оролцоо |
| B. Нийгмийн гишүүдийн дийлэнхийнх нь итгэл үнэмшил, дадал заншил болсон, тэдгээрээс улс төрийн систем, төр засагтаа хандах байдлыг илэрхийлсэн шинжлэх ухааны ойлголт | 2. Нийцгүй оролцоо |
| C. Хууль бус жагсаал цуглаан, ажил хаялтад оролцох, татвар төлөхөөс зайлсхийх, байшин барилга эзлэх зэргээр илэрнэ | 3. Улс төрийн дуулгавар |
| D. Хувь хүний зүгээс нийгмийн тодорхой хүчийг хүлээн зөвшөөрч, түүний шаардлага, шийдвэрийг биелүүлж, захирагдах явдлаар илэрнэ | 4. Улс төрийн хэм хэмжээ |
| E. Сонгуульд оролцох, бүх ард түмний санал асуулгад оролцох, төрийн байгууллагад захидал бичих хэлбэрүүдийг хэлнэ | 5. Улс төрийн соёл |

2.2. Зөв харгалзааг тогтооно уу. (5 оноо)

| | |
|---|---|
| A. А.Линкольн | 1. Хүн бол улс төрийн амьтан |
| B. У.Черчилль | 2. Улс төрийн систем нь үнэт зүйлийг эрх мэдэлтэйгээр . хуваарилан байршуулах үйл байдал |
| C. В.И.Ленин | 3. Ардчилал бол ард түмнээс сонгогдсон, ард түмний тө, төлөө, ард түмний өөрсдийнх нь засаглал юм |
| D. Аристотель | 4. Төр бол нэг анги нөгөөгөө дарангуйлах машин |
| E. Д.Истон | 5. Ардчилал бол хамгийн муу засаглал. Гэхдээ хүн төр төрөлхтөн үүнээс илүүг олоогүй байна |

2.3. Олон улсын харилцааны онолуудыг зөв харгалзуулна уу. (4 оноо)

| | |
|---|---|
| A. Идеализм | 1. Олон улсын харилцаанд улсууд, олон улсын байгууллагууд, үндэстэн дамнасан аж ахуй, олон нийтийн бүтцүүд идэвхтэй оролцох болсон бөгөөд өөр хоорондоо нягт холбогдсон харилцан хамааралтай байна гэж үздэг |
| B. Реалист | 2. Мөргөлдөөныг багасгах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, үндэстнүүдийн хоорондын харилцааг нэмэгдүүлэхэд анхаарсан. |
| C. Плюрализм (глобализм) | 3. Пролетарийн хувьсгал хийж дэлхий дээр үндэстэн, үндэстэний улс үгүй болно. Олон улсын харилцаа бол баян, ядуугийн тэнцэл юм гэж үзсэн |
| D. Марксизм | 4. Олон улсын харилцааны мөн чанар бол тусгаар улсуудын өөрийгөө хамгаалах, сонирхолоо хэрэгжүүлэх эрмэлзэл, өрсөлдөөн, хүчний тэнцвэр гэж үзсэн |

## ХУВИЛБАР B

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Нийгэм нь шатлал бүхий бүлгүүдэд хуваагдах бөгөөд дотроо шатлан захирах ёсонд хатуу тогтоосон байр суурь эзэлдэг эрэмбэ бүхий хаалттай бүлгийг … гэнэ. (1оноо)
   A. Боолчлол B. Кастын хэв маяг C. Язгуур угсааны хэв маяг
   D. Хаалттай хэв маяг E. Тэгш бус байдал
2. "Атомист" онолын хандлагаар бол нийгэм нь оршин амьдарч буй бие хүмүүс, тэдгээрийн хоорондын социал харилцааны цогц юм. "Атомист" онолын төлөөлөгч хэн бэ? (1оноо)
   A. Г.Зиммель B. Э.Шилз C. К.Маркс
   D. Т.Парсонс E. Т.Мальтус
3. Нийгэм түүхийг үзэх дараах онол сургаалын үзэл, гол төлөөлөгчдийг зөв харгалзуулаарай. (3 оноо)

| | |
|---|---|
| 1. Л.Н.Гумилев, Л.И.Мечников, Ш.Монтеське | a. Нийгмийг амьтны физиологийн бүтэцтэй адилтган интеграци, дифференциацийн зарчмаар тайлбарлах үзэл |
| 2. Ч.Дарвин, У.Беджгот, Л.Гумплович, Ж.Гобино | b. Нийгмийн хөгжилд хүн амын тоо, хүнс тэжээлийн нөөц чухал үүрэгтэй |
| 3. Т.Мальтус | c. Тухайн улс үндэстний хөгжилд газар зүйн орчин, уур амьсгал хөрс, усан мандал чухал үүрэгтэй |

   A. 1a 2b 3c B. 1b 2c 3a C. 1c 2b 3a D. 1c 2a 3b E. 1a 2c 3b
4. Аль нь уламжлалт нийгмийн шинж биш вэ? (1оноо)
   A. Хөдөлмөрийн хуваарь, төрөл мэргэжил нь байгалийнх байдаг
   B. Хувь хүмүүсийн хооронд албан биш хувийн харилцаа давамгайлдаг
   C. Хүмүүсийн харилцаа нь ёс заншил, зан үйлд тулгуурладаг
   D. Удирдлагын болхи системтэй
   E. Удирдлагын нийлмэл систем бий болсон
5. … гэдэг бол соёлоос хожуу үүссэн ч дэлхийчлэлийн цар хүрээний ач холбогдолтой, нийгэм ба нийгэмлэгүүдийн соёлын хөгжлийн шат, түвшин болон тэдгээрийн өвөрмөц шинжийг тусгасан ойлголт юм. (1оноо)
   A. Нийгэм B. Иргэншил C. Соёл
   D. Нийгэмшил E. Иргэний нийгэм
6. Нийгмийн институтыг зөв тодорхойлсон өгөгдлийг олно уу. (2 оноо)
   A. Нийгэмд зөвшөөрч буй зоримж, зан заншил, дэг журам
   B. Нийгмийн хэм хэмжээний анхны хэлбэр
   C. Нийгмийн чухал хэрэгцээнүүдийг хангах, нийгмийн хэм хэмжээг зохицуулах чиг үүрэгтэй тохируулагч байгууламж
   D. Улс төрийн байгууламж
   E. Зөв тодорхойлолт алга
7. Тухайн нутаг дэвсгэр дээрх юмуу бүлгийн бүх хүнийг хамруулахгүйгээр харин тодорхой төлөөллийн үзүүлэлтүүдийг сонгон судлах нь …...... юм. (1 оноо)
   A. Анкетын арга B. Түүврийн арга C. Ажиглалтын арга
   D. Индукцийн арга E. Дедукцийн арга
8. Манай улс социалист хөгжлийн замд орсныг гэрчлэх баримт бичиг аль нь вэ? (1 оноо)
   A. 1924 оны үндсэн хууль B. 1940 оны үндсэн хууль C. 1960 оны үндсэн хууль
   D. 1992 оны үндсэн хууль E. Зөв хариулт алга
9. Нийт ард түмний хэрэгцээ, ашиг сонирхлыг хэрэгжүүлэх явц дахь хүмүүсийн харилцан үйлдэл ба харилцааг зохицуулан тохируулах чиг үүрэг нийгмийн амьдралын аль хүрээнд хэрэгжих вэ? (1 оноо)
   A. Улс төрийн хүрээнд B. Социал хүрээнд
   C. Эдийн засгийн хүрээнд D. Оюуны амьдралын хүрээнд
   E. Зөв хариулт алга
10. Социал дэвшлийг шинэтгэлийн ба хувьсгалын хэмээн ангилан авч үздэг. Нийгмийн хувьсгалын шинж аль нь вэ? (2 оноо)
   A. Оршин буй социал тогтолцооныхоо үндсийг хөндсөн, нийгмийн амьдралын ихэнх хүрээг өөрчлөх үйл явц
   B. Оршин буй социал тогтолцооныхоо үндсийг хөндөлгүйгээр нийгмийн амьдралын аль нэг хүрээн дэх хэд хэдэн байнгын жигд тогтвортой өөрчлөлтийн үйл явц
   C. Нийгмийн хөгжлийн хурдац нь нийгэмд эерэг хандлага, үр дагавар авчрах үйл явц

D. Нийгэм, түүхийн хурдац нь нийгэмд сөрөг үр дагавар авчрах үйл явц
E. Нийгмийн улс төрийн амьдралд шинэтгэл хийх үйл явц

11. "Мобиком" корпорацид менежер хийж байсан Т ажилдаа чадваржин улмаар салбар нэгжийн захирлаар томилогдов. Энэ нь шилжих хөдөлгөөний аль хэлбэрт хамаарах вэ? (1 оноо)
A. Үе хоорондын шилжих хөдөлгөөн B. Босоо шилжих хөдөлгөөн
C. Уруудах шилжих хөдөлгөөн D. Хэвтээ шилжих хөдөлгөөн
E. Бүлгийн шилжих хөдөлгөөн

12. Улс төрийн системийн оролт, гаралт нь дараах ойлголтуудын алинаар нь дамжин хоорондоо харилцан шүтэлцэж байдаг вэ? (1 оноо)
A. Дэмжлэг B. Шаардлага C. Эргэх холбоо
D. Үйлдэл E. Шийдвэр

13. Хувьсгал, ангийн тэмцэл, сонгуулийн компани, төрийн тэргүүний айлчлал, дипломат гэрээ хэлэлцээр зэрэг нь аль ухагдахууныг илэрхийлэх вэ? (1 оноо)
A. Улс төрийн хошуучлал B. Улс төрийн үйл ажиллагаа C. Улс төрийн оролцоо
D. Улс төрийн харилцаа E. Улс төрийн соёл

14. Элитийн засаглалын хүч чадал, гол эх сурвалж нь дотоод зохион байгуулалт, эв нэгдэл хэмээн үзсэн эрдэмтэн аль нь вэ? (1 оноо)
A. Г.Моска B. Д.Истон C. М.Вебер
D. Г.Алмонд E. К.Маркс

15. Хүмүүсийн амьдралын наад захын нөхцөл бололцоо, нийгмийн хамгааллаар хангахад илүү чиглэсэн бодлого явуулах зорилго бүхий төрийн хэв маягийг … гэнэ. (1оноо)
A. Төрийн хэлбэр B. Эрх зүйт төр C. Социал төр
D. Төрийн дэглэм E. Төрийн байгууламжийн хэлбэр

16. Гэр бүлийн хэв маягаас аль нь эхнэр, нөхрийн эрх тэгш байдлыг илэрхийлдэг вэ? (1 оноо)
A. Патриархаль B. Эгалитар C. Матриархаль
D. Полигами E. Полиандри

17. Хүсэл зорилгоо хэрэгжүүлэх арга чадвар, боломжийг … гэнэ. (1 оноо)
A. Эд баялаг B. Эрх мэдэл C. Нэр хүнд
D. Орлого E. Албан тушаал

18. Тусгай юмс үзэгдлүүд, баримтуудаас ерөнхий үндэслэл, дүгнэлт гаргах нь … юм. (1 оноо)
A. Анкетын арга B. Анализ C. Синтез
D. Индукцийн арга E. Дедукцийн арга

19. Нийгмийн жижиг бүлгийн үндсэн шинжийг тодорхойлно уу. (1 оноо)
A. Гишүүд нь орон зайн хувьд ойр байдаг
B. Гишүүдийн зан байдлыг албан бусаар хянадаг
C. Бүлэгт сайн дурын үндсэн дээр элсдэг
D. A, C хариулт зөв
E. Дээрх бүгд

20. Засаглалыг Хууль тогтоох, Гүйцэтгэх, Шүүх гэж гурав ангилсан эрдэмтэн аль нь вэ? (1 оноо)
A. М.Вебер B. Т.Парсонс C. Д.Истон
D. Ш.Монтескье E. В.Парето

21. Монгол улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 5-д, "... Өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй" гэж заасан нь ........баталгаа юм. (1 оноо)
A. Манай төр социал төрийн баримжаатай гэдгийн
B. Манай төр эрх зүйт төрийн баримжаатай гэдгийн
C. Хүмүүсийн байгалиас заяасан тэгш бус байдлыг засч залруулах
D. Эдийн засгийн либерализм зах зээлийн зохицуулалтад давуу байдал олгодгийн
E. Төр, иргэний нийгэм хоёр эрхзүйт хуулийн үндсэн дээр тэнцвэртэй орших

22. Засаглалын легитим шинжийг хэрхэн ойлгож болох вэ? (1 оноо)
A. Хүчирхийлэлд тулгуурласан засаглал
B. Иргэд эрх баригчдын захирах эрхийг зүй ёсны хэмээн хүлээн зөвшөөрөх
C. Улс төрийн хошуучлалын нөлөөлөл
D. Засгийн газар огцрох
E. Засаглалын ялан дийлэх чадвар

23. Сонгуулийн хэмжээс буюу босго тогтоох арга хэрэглэн босгыг сонгогчдын тооноос хамааруулан тойрог бүрт янз бүр байхаар, эсхүл улсын хэмжээгээр нэг адил байхаар тогтоодог нь сонгуулийн аль систем бэ? (1 оноо)

A. Мажоритар B. Пропорциональ C. Холимог
D. Сонгуулийн систем E. Суудал хуваарилах

24. Ардчилсан бус дэглэмийн гол шинж аль нь вэ? (1 оноо)
A. Өмчийн олон хэлбэр
B. Улс төрийн плюрализм
C. Улс төрийн болон иргэний соёлд төр тулгуурлах
D. Хүний эрхийг баталгаажуулахад төрийн үзэл суртлыг чиглүүлэх
E. Хүний эрх, эрх чөлөөг нэг үзэл сурталд захируулах

25. Улс төрийн соёлын ангиллыг зөв харгалзуулна уу. (3 оноо)
1. Улс төрийн соёлыг хэрэгжих хүрээгээр нь — a. Нам, эвсэл холбоодын
2. Улс төрийн соёлыг түвшингээр нь — b. Оролцогчдын буюу идэвхтэй, хамжлагын буюу албадлагын гэх мэт
3. Улс төрийн соёлыг хөгжлийн байдлаар нь — c. Танин мэдэх, сэтгэл хөдлөлийн, үнэлэх
A. 1a 2b 3c B. 1c 2b 3a C. 1a 2c 3b
D. 1c 2a 3b E. 1b 2c 3a

26. Монгол улс МЭӨ III зуунаас 1920-иод оны дунд үеийг хүртэл хаант засаглалтай байсан бол дараа нь Бүгд Найрамдах засаглалтай болж өөрчлөгджээ. Энэ нь төрийн хэлбэрийн хувьд аль бодомжид тохирох вэ? (2 оноо)
A. Улс үндэстэн төрийн ямар хэлбэртэй байх нь тэдний хүсэл зоригийн хэрэг
B. Төрийн хэлбэр нь тухайн улсын хувьд мөнхийн хөдөлгөөнгүй хэвшмэл зүйл
C. Төрт ёс нь дэлхий нийтийн уламжлалт тогтолцоог хадгална
D. Төрийн хэлбэр нь нийгэм хөгжих тусам шинэ агуулгаар баяжиж өөрчлөгдөж байдаг
E. Төрийн хэлбэр нь өөрийн уламжлалаа бусад улс үндэстэнд дэлгэрүүлдэг

27. Зах зээл гэдгийг хэрхэн ойлгож болох вэ? (1 оноо)
A. Юуг, яаж, хэний төлөө гэсэн асуултын үүднээс нийгмийн эрэлт хэрэгцээг хангахад бүрэн чиглэсэн нэгдмэл цогц ойлголт
B. Бүтээгдэхүүн болон үйлчилгээ, үйл ажиллагааны үр дүнг солилцохын тулд үйлдвэрлэгч, хэрэглэгч нар үнэ, тоо хэмжээг тодорхойлж харилцан ажиллах хүрээ
C. Нийгмийн эрэлт хэрэгцээг хангахад бүрэн чиглэсэн таваарын үйлдвэрлэл, хуваарилалт, арилжаа хэрэглээний нэгдмэл цогц
D. Хүн төрөлхтний олон үеийн амьдралын хөгжлөөр шалгарсан, нийгмийн үйлдвэрлэлийг өсгөн нэмэгдүүлэх, хүмүүсийн хэрэгцээг илүү сайн хангах үр дүнтэй хэрэгсэл
E. Бүх хариулт хамаарна

28. Үнэ буурвал эрэлтийн тоо хэмжээ нэмэгдэж, үнэ өсөхөд эрэлтийн тоо хэмжээ буурах барааг ямар бараа гэх вэ? (1 оноо)
A. Хэвийн бараа B. Онцгой бараа C. Өргөн хэрэглээний бараа
D. Энгийн бараа E. Дорд бараа

29. … нь захиргаадалтын эдийн засгийн үндсэн шинж мөн. (1 оноо)
A. Хувийн өмч
B. Ашгийн төлөө хөөцөлдөх
C. Эдийн засагт төрийн оролцоо хязгаарлагдмал байх
D. Зан заншил, уламжлалд тулгуурлах
E. Эдийн засагт төрийн оролцоо их байх

30. ҮНБ-ийг зарцуулалтаар тооцохдоо ямар үзүүлэлтийг харгалзахгүй вэ? (1 оноо)
A. Түрээс B. Хэрэглээ C. Хөрөнгө оруулалт
D. Улсын зарцуулалт E. Цэвэр экспорт

31. Үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний тоо хэмжээ урьдын адил байхад нэмж ажилчин авч ажиллуулснаар хугацаа хэмнэсэн бол … (1 оноо)
A. Хөдөлмөрийн бүтээмж өснө B. Хөдөлмөрийн бүтээмж буурна
C. Материалын бүтээмж өснө D. Материалын бүтээмж буурна
E. Ашиг нэмэгдэнэ

32. Хүний хөгжлийн индекс юугаар тодорхойлогдох вэ? (1 оноо)
A. Эрүүл энх удаан амьдрал, мэдлэг, амьжиргааны түвшний үзүүлэлтүүд
B. Эрүүл энх, урт удаан амьдрал, боловсрол, 1 хүнд ноогдох ҮНБ-ий хэмжээ
C. Наслалт, мэдлэг, 1 хүнд ноогдох ҮНБ
D. Амьжиргааны түвшний үзүүлэлтүүдийн нэгдсэн индекс
E. Аль нь ч биш

33. Төрийн бус байгууллага, сангийн өмч гэдэгт алийг нь хамааруулан ойлгож болох вэ? (1 оноо)
   A. Гишүүд дэмжигчдийн татвар, хандив
   B. Дүрэмд нийцсэн үйл ажиллагааныхаа үр дүнд олсон орлого
   C. Буян үйлдэх зүйл, барилга, шүтээн
   D. Археологи, палеонтологийн олдвор
   E. A ба B хариулт зөв
34. Хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхийн тулд хэрхвэл зохистой вэ? (1 оноо)
   A. Нэгж хугацаанд үйлдвэрлэх бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлэх
   B. Хүмүүсийг олноор ажиллуулах
   C. Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх хугацааг богиносгох
   D. Үйлдвэрлэлийнхээ хүрээг тэлэх
   E. A ба C хариулт зөв
35. Төрийн санхүүд аль нь хамааралгүй вэ? (1 оноо)
   A. Улсын төсөв B. Төсвийн гадуурх улсын сангууд
   C. Улсын нийгмийн даатгал D. Улсын эд хөрөнгийн даатгал
   E. Хүн амын санхүүгийн орлого
36. Хөдөлмөрийн бүтээмжид нөлөөлдөг хүчин зүйлсийг дурдахдаа илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? (1 оноо)
   A. Ажиллагсдын боловсрол B. Ажиллагсдын урам зориг, сонирхол
   C. Ажиллагсдын гарал, нийгмийн байдал D. Хөдөлмөрийн зохион байгуулалт
   E. Тоног төхөөрөмжийн чанар
37. Аль нь чөлөөт зах зээлийн тогтолцооны үндсэн шинж вэ? (1 оноо)
   A. Ашгийн хойноос хөөцөлдөх
   B. Бүх шийдвэрийг төлөвлөгөөгөөр гаргана
   C. Орлогын хуваарилалт нь зан заншилд тулгуурладаг
   D. Эдийн засагт төрийн оролцоо өндөр байдаг
   E. Дээрх бүгд
38. Нийлүүлэлт нэмэгдвэл ........ . (1 оноо)
   A. Үнэ өснө, тоо хэмжээ өснө B. Үнэ буурна, тоо хэмжээ буурна
   C. Үнэ буурна, тоо хэмжээ өснө D. Үнэ өснө, тоо хэмжээ буурна
   E. Тэнцвэрт үнэ тогтоно
39. Хэрэглээний үнийн индексийг хэрхэн тодорхойлдог вэ? (1 оноо)
   A. Тухайн онд авсан сагсны зах зээлийн үнийг суурь жилийн барааны сагсны үнэд харьцуулна
   B. Тухайн онд авсан сагсны зах зээлийн үнийг өмнөх жилүүдийн барааны сагсанд харьцуулна
   C. Инфляцийн түвшний өөрчлөлтөөр тодорхойлно
   D. Тодорхой хугацааны завсар дахь үнийн нийт түвшний өөрчлөлтийн хувиар илэрхийлнэ
   E. Аль алинаар нь тодорхойлж болно
40. Монгол улсын Төв банк нь тайлангаа хаана гаргах вэ? (1 оноо)
   A. Дээд шүүхэд B. Засгийн газарт C. УИХ-д
   D. Сангийн яаманд E. Хэнд ч тайлагнахгүй
41. Татвар тооцох, ноогдуулах журмыг зөв харгалзуулна уу. (3 оноо)

| | |
|---|---|
| 1. Декларацийн арга | a. Цалин, хөдөлмөрийн хөлс, ноогдол ашиг, хадгаламжийн хүүгийн орлогод татвар ноогдуулахад тухайн орлогыг олгож байгаа байгууллага хэрэглэх арга |
| 2. Кадастрын арга | b. Гол төлөв газар, үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгслийн бүртгэл хөтөлж, тэдгээрт хөрөнгийн татвар ноогдуулах журам |
| 3. Суутгалын арга | c. Татвар төлөгч тодорхой хугацаанд олсон орлогоо татварын албанд тусгай маягтаар мэдэгдэх |

   A. 1b 2c 3a B. 1c 2b 3a C. 1c 2a 3b
   D. 1b 2a 3c E. 1a 2b 3c
42. Оёдлын үйлдвэрт хэдэн шинэ машин нэмж суурилуулав. Ингэснээр … (2 оноо)
   A. Нийт бүтээмж өснө
   B. Нийт бүтээмж буурна
   C. Тоног төхөөрөмжийн бүтээмж буурна
   D. Тоног төхөөрөмжийн бүтээмж өснө
   E. Нийт гарц мэдэгдэхгүй байгаа тул бүтээмжийн өөрчлөлтийг тооцох боломжгүй
43. Дараах өгөгдлийн аль нь эд баялгийн үйлчилгээ вэ? (2 оноо)
   A. Сүүний үйлдвэр B. Хонины аж ахуй C. Орон сууц барих
   D. Гутлын үйлдвэрлэл E. Нийтийн тээвэр

44. Эдийн засгийн дараах зорилтуудаас аль нь тодорхой тоон хэмжүүртэй байдаг вэ? (2 оноо)
    A. Эдийн засгийн баталгаа B. Эдийн засгийн эрх чөлөө
    C. Ажил эрхлэлтийн түвшин D. Орлогын шударга хуваарилалт
    E. Эдийн засгийн хууль
45. Ахиу орлогыг хэрхэн тодорхойлох вэ? (2 оноо)
    A. Бүтээгдэхүүний үнэ, борлосон бүтээгдэхүүний хэмжээгээр илэрхийлэгдэнэ
    B. Гарцын борлуулалт нэг нэгжээр өөрчлөгдөхөд нийт орлогод гарах өөрчлөлтөөр хэмжигдэнэ
    C. Гарцын борлуулалтыг нийт орлогод харьцуулна
    D. Борлогдсон бүтээгдэхүүний хэмжээг бүтээгдэхүүний үнэд харьцуулна
    E. Нийт орлого, зарлагын зөрүү
46. Зах зээлийн төрлүүдийг зөв харгалзуулна уу. (3 оноо)

| | |
|---|---|
| 1. Чөлөөт өрсөлдөөний зах зээл | a. Нэгэн төрлийн бүтээгдэхүүн олон, үнийг зах зээл тодорхойлно |
| 2. Олигополь | b. Нэгэн төрлийн бүтээгдэхүүн олон, үнийн манлайлах нөлөө байдаг |
| 3. Монопольт өрсөлдөөн | c. Ялгавартай бараа бүтээгдэхүүнтэй, үнийн нөлөөлөл хязгаарлагдмал |

    A. 1a 2b 3c B. 1a 2c 3b C. 1b 2c 3a
    D. 1b 2a 3c E. 1c 2a 3b
47. Хүмүүс өөрсдийнхөө янз бүрийн үйл ажиллагааг ивээн тэтгэж байдаг янз бүрийн бурхад оршдог хэмээн сэтгэж олон бурхны тухай хийсвэрлэл гаргаж ирсэн. Энэ нь шүтлэгийн аль хэлбэр вэ? (2 оноо)
    A. Монотеизм B. Политеизм C. Анимизм
    D. Тотемизм E. Фетишизм
48. Соёлын хэлбэрүүдийг зөв харгалзуулна уу. (3 оноо)

| | |
|---|---|
| 1. Соёлыг өргөжин тэлэх хандлагаар нь ангилах ангилал | a. Мэргэжлийн, үндэсний, шашны |
| 2. Соёлын босоо чиглэл дэх ангилал | b. Иргэншлийн, бүс нутгийн, угсаатны, үндэсний, орон нутгийн хэв маягийн |
| 3. Дэд соёлын ангилал | c. Элитийн, ардын, нийтийн, зонхилогч, дэд, сөрөг |

    A. 1a 2b 3c B.1a 2c 3b C. 1b 2a 3c
    D.1b 2c 3a E.1c 2b 3a
49. Дараах үзэгдлүүдээс аль нь нийгэмд илүү хор уршиг авчрах вэ? (2 оноо)
    A. Хулгай, дээрэм тонуул
    B. Садар самуун явдал
    C. Нийтийг хамарсан архидан согтуурах явдал
    D. Тамхийг өргөн хэрэглэх
    E. Этгээд хувцаслалт
50. Алдарт аялагч Марко Полотой цуг явсан хятад тогооч Италид шпагеттийн жорыг авчирсан ба хожим нь Италийн цагаачид Америкт дэлгэрүүлжээ. Энэ алинаар нь тайлбарлагдах вэ? (2 оноо)
    A. Соёлын өөрчлөлтийн эх үүсвэр B. Соёлын диффузи
    C. Соёлын олон талт байдал D. Соёлын универсал
    E. Этноцентризм
51. Соёлын нэвчих үзэгдлийн сувгуудыг тоочихдоо хамаарахгүй зүйл оруулсан бол аль нь вэ? (2 оноо)
    A. Цагаачлал B. Жуулчлал C. Худалдаа
    D. Үйлдвэрлэл E. Дайн
52. Ёс суртахууны үндсэн ойлголт аль нь вэ? (2 оноо)
    A. Сайхан, муухай B. Сайн, муу C. Үнэн, худал
    D. Нүгэл, буян E. Дээрх бүгд
53. Өгөгдлийг зөв харгалзуулна уу. (4 оноо)

| | |
|---|---|
| 1. Соёлын албан бус хэм хэмжээ | a. Бүхий л соёлд нэгэн адил хамаардаг ерөнхий үнэт үйлс з |
| 2. Соёлын универсал шинж | b. Олон түмний санал сэтгэгдлээр дэмжигдэж байдаг сайн мууг тодорхойлогч ерөнхий дүрэм журам |
| 3. Соёлын өвөрмөц шинж | c. Монгол улсын иргэн сонгох, сонгогдох эрхтэй |
| 4. Албан ёсны хэм хэмжээ | d. Араб эмэгтэйчүүд нүүрээ халхалсан гивлүүр зүүдэг |

    A. 1a 2b 3c 4d B. 1b 2a 3d 4c C. 1d 2c 3b 4a
    D. 1c 2a 3b 4d E. 1b 2d 3a 4c

54. Шашны нийгмийн үүргийг дурдахдаа илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? (2 оноо)
   A. Үнэт зүйлийн үүрэг
   B. Зохицуулах болон хэм хэмжээний үүрэг
   C. Хүмүүсийг нэгтгэх, туслалцаа үзүүлэх үүрэг
   D. Ертөнцийг үзэх үзлийн үүрэг
   E. Амьдралын баталгааг хангах үүрэг
55. "Энхийн төлөөх түншлэл" хөтөлбөрийг боловсруулан дэлхийн энх тайвны төлөө ажиллах болсон олон улсын байгууллага аль нь вэ? (2 оноо)
   A. АСЕАН B. ШХАБ C. АПЕК
   D. НАТО E. Олон улсын энхийг сахиулах хүчин
56. Дэлхийн улс орнууд зайлшгүй харилцах шаардлагад хамаарахгүй нь аль вэ? (2 оноо)
   A. Бусад улстай харилцсанаар өөрийн байр суурийг дэлхийд таниулах
   B. Үндэсний соёл, уламжлалаа хөгжүүлэх
   C. Гадаад орчинтой харилцаж байж зарим хэрэгцээгээ хангаж байдаг
   D. Улс орныхоо аюулгүй байдлыг батлан хамгаалах
   E. Улс орнуудын түүх, соёлыг судлах суралцах боломж нээгддэг
57. Индонез, Тайланд, Малайз, Сингапур, Филиппин, Бруней зэрэг гишүүн оронтой бөгөөд бүс нутгийн хүрээнд энх тайван байдал, тогтвортой хөгжлийг хангаж бэхжүүлэх үйл ажиллагаа явуулдаг байгууллага аль нь вэ? (2 оноо)
   A. АСЕАН B. ШХАБ C. АПЕК
   D. Европын холбоо E. АСЕМ

## ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу. (5 оноо)

| | |
|---|---|
| A. Мөнгөний бодлого | 1. Энэ бодлогын үед инфляци саарах боловч бодит хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл багасч, ажилгүйдэл өсөх магадлалтай |
| B. Хүүгийн бодлого | 2. Мөнгөн тэмдэгт, зоос гүйлгээнд гаргах онцгой эрх эдлэх үйл ажиллагаа |
| C. Мөнгөний хатуу бодлого | 3. Төв банк хүүгээ бууруулснаар бодит хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл нэмэгдэх боловч инфляци өсөх хандлагатай |
| D. Мөнгөний зөөлөн бодлого | 4. Эдийн засаг дахь мөнгөний нийт тоонд болон хүүгийн хэмжээнд нөлөөлөх |
| E. Эмисс | 5. Төв банкнаас арилжааны банкуудад олгох зээлийн хүү, хэмжээг мөнгөний ханш уналтын түвшинтэй хамааралтайгаар тогтоох үйл явц |

2.2. Өгөгдлийг зөв харгалзуулна уу. (5 оноо)

| | |
|---|---|
| A. Улс төрийн хүлээцтэй байдал | 1. Бүх хүнийг ижил боломжтой байлгаж, арьс өнгө, шашин шүтлэг, үндэс угсаа, хүйсээр ялгаварлахгүй |
| B. Иргэдийн оролцоо | 2. Ард түмний олонх улс орныг удирдаж байхад цөөнхийн эрхийг хамгаалсан байх ёстой |
| C. Тэгш эрх | 3. Хүн бүр хуулийг сахина, зөрчвөл хариуцлага хүлээнэ |
| D. Чөлөөт шударга сонгууль | 4. Иргэд өөрсдийнхөө талаар шийдвэр гаргахад идэвхтэй үйл ажиллагаа явуулах, бие даасан байр сууръ баримтлах |
| E. Хуульд захирагдах ёс | 5. Төр засагт өөрсдийгөө төлөөлөх албан тушаалтныг ажиллуулах, солих |

2.3. Нийгмийн тухай үзэл, хандлагуудыг зөв харгалзуулна уу. (4 оноо)

| | |
|---|---|
| A. Институтын хандлага | 1. Нийгэм нь бүхэллэг тогтолцоо болохынхоо хувьд эдийн засаг, нийгэм, улс төр, үзэл суртал зэрэг дэд тогтолцоонуудад хуваагддаг |
| B. Шалтгаант чанарын хандлага | 2. Нийгмийн институтын хүрээн дэх социал амьдралыг хэрэгжүүлж буй хүмүүсийн цогцыг нийгэм гэнэ |
| C. Функционализм | 3. Ангиудын хоорондын зөрчил нийгмийн үндэс язгуурт байдаг |
| D. Мөргөлдөөний онол | 4. Үүргээ алдах явдал үнэндээ тохиолддог бөгөөд энэ нь аяндаа засагдах буюу эцэс сүүлдээ нийгэмд бэхжин тогтож болно |
| E. Хуульд захирагдах ёс | 5. Төр засагт өөрсдийгөө төлөөлөх албан тушаалтныг ажиллуулах, солих |

## ХУВИЛБАР С

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Хүний нийгмийн хөгжлийг зэрлэг, бүдүүлэг, соёлт үе гэж хэн ангилсан бэ? (1 оноо)
   A. У.У.Ростоу B. О.Шпенглер C. К.Маркс
   D. Л.Г. Морган E. Ф.Энгельс
2. Нийгмийн давхраажилт нь (1 оноо)
   A. Тэгш байдалтай холбогдох ойлголт
   B. Нийгмийн ижил төстэй байдалтай холбогдоно
   C. Тэгш байдал ба нийгмийн зэрэглэл оршиж байгааг илтгэнэ
   D. Нийгмийн тэгш бус байдал ба зэрэглэл, шатлал оршиж буйг илтгэнэ
   E. Орлогын ялгааг харуулна
3. Түүхэн явцад бүрэлдэн тогтсон хүмүүсийн томоохон тогтвортой хамтлаг, нийтлэгүүдийн зүй зохистой, зорилго чиглэлтэй, зохион байгуулагдсан хамтын үйл ажиллагааны цогц үр дүн гэсэн нь доорх өгөгдлөөс алийг нь илүү илэрхийлж байна вэ? (1 оноо)
   A. Нийгэм B. Үндэстэн C. Ард түмэн
   D. Угсаатан E. Энэ гурваас өөр нэгдэл
4. Хүн төрөлхтний түүхэнд төргүй үе байсан. Хүмүүс аль үед төргүйгээр амьдарч байсан бэ? (1 оноо)
   A. Хүй нэгдлийн байгууллын үед B. Дундад зууны үед
   C. Хүн төрөлхтний хөгжлийн дунд үед D. Тийм үе байгаагүй
   E. 13-р зууны үед
5. Улс төр гэдэг нь нийгмийн гишүүдийн эрс зөрүүтэй байдлаас шалтгаалаад тусгай арга хэрэгсэлгүйгээр шийдвэр гаргах боломжгүй нөхцөлд нийгэмд хамтын шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх………………. хэлнэ. (1 оноо)
   A. Арга зам B. Бодлого чиглэл C. Хандлага
   D. Үйл ажиллагаа E. Нөхцөл байдал
6. …………………..бол нийгмийн зохион байгуулалттай тодорхой хүчнээс хүн амын янз бүрийн бүлгийн харилцаа ба үйл ажиллагаагаар өөртөө учруулах бэрхшээл эсэргүүцлийг даван туулж өөрийн зориг хүслийг эрхзүй, ёс суртахууны зэрэг нийтлэг хэм хэмжээгээр хүлээн зөвшөөрүүлэх чадвар юм. (1 оноо)
   A. Төрийн засаглал B. Хүч чадал C. Улс төрийн ёс суртахуун
   D. Улс төрийн хүсэл зориг E. Улс төрийн засаглал
7. Улс төрийн амьдрал нэг талаасаа зөрчилт чиглэлийг агуулж байдаг. Тиймээс энэ утгаараа улс төр гэдэг нь “хэн, юуг, хэзээ, хэрхэн олж авах” тухай асуудал юм гэж хэн тодорхойлсон бэ? (1 оноо)
   A. К. Маркс B. Р. Даль C. Х. Лассуэл
   D. Аристотель E. Б. Рассель
8. Эрх мэдлийг ангилах шалгуур үзүүлэлт маш олон төрөл байдаг хэдий ч бид эрх мэдлийг ангилах дараах үзүүлэлтүүдийг авч үзсэн болно. Тэгвэл дараах ангиллын зөв харгалзааг тогтооно уу? (2 оноо)

| | |
|---|---|
| 1. Эрх мэдлийг субъектээр нь | а. Ардчилсан, ардчилсан бус |
| 2. Хэрэгжүүлж буй аргаар нь | б. Гэр бүлийн, цэргийн, намын |
| 3. Тулгуурлаж буй эх сурвалжаар нь | в. Эдийн засгийн, мэдээллийн, албадлагын |
| 4. Багтаамжаар нь | г. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх |
| 5. Гүйцэтгэж буй үүргээр нь | д. Бага, дунд, өргөн |

   A. 1б2а3в4д5г B. 1в2а3б4д5г C. 1а2б3в4г5д
   D. 1г2а3в4д5б E. 1д2а3в4г5б
9. Эдийн засгийн бодит хууль нь………………..илэрхийлэгдэнэ. (1 оноо)
   A. Татварын багц хуулиар
   B. Худалдааны болон гаалийн хуулиар
   C. Эрэлт нийлүүлэлтийн хуулиар
   D. Монополийн эсрэг хуулиар
   E. Хөдөлмөрийн хуулиар
10. 1991 оноос Монголд бага хувьчлалын үе эхэлсэн бөгөөд Монголын засгийн газраас ард түмэндээ олгосон анхны хувийн өмчийн хэлбэр юу вэ? (2 оноо)
   A. Мал B. Орон сууц C. Улсын үйлдвэр
   D. Хувьцаа E. Газар
11. 1930-аад оны үеийн дэлхийн эдийн засгийн хямралын шалтгааныг тодорхойлж зах зээлд төрийн зохицуулалт зайлшгүй шаардлагатайг онцолсон эдийн засагч хэн бэ? (1 оноо)

A. А. Смит B. М. Кейнс C. А. Маршал
D. К. Маркс E. Ф. Энгельс

12. Цэгийн оронд тохирохыг сонго. Соёлуудын харилцан тархалт, дэлгэрэлтийг соёлын………………үзээгдэл гэнэ. (1 оноо)
A. Холбох B. Нэвчих C. А ба В хариулт зөв
D. Холилдох E. Аль нь ч биш

13. Мэндчилгээ, зочлох ёс, харилцааны хэв маяг, орон байр, хоол бэлтгэх, ажилдаа хандах хандлага зэрэг нь…………….. (1 оноо)
A. Соёлын түгээмэл шинжийг илэрхийлнэ B. Соёлын олон талт байдлыг илэрхийлнэ
C. Соёлын түгээмэл биш шинжийг илэрхийлнэ D. Соёлын онцгой шинжийг илэрхийлнэ
E. Аль нь ч биш

14. Олон улсын харилцааны гол субъектүүдийг тоочихдоо илүүц зүйл дурьдсан бол аль нь вэ? (1 оноо)
A. Төр B. Ард түмэн
C. Олон улсын байгууллага D. Үндэстэн дамнасан корпараци
E. Гадаадын хөрөнгө оруулалттай ХХК

15. Тодорхой улс орон, ард түмэн түүхэн хөгжлийн шатан дахь нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын тогтвортой хамтын ажиллагаа, харилцан үйлчлэл, хэрэгцээ, сонирхлын ялгаа, зөрчилдөөн бүхий хүмүүсийн том нэгдэл гэсэн нь алийг нь илүү илэрхийлж байна вэ? (1 оноо)
A. Улс орон B. Нийгэм C. Төр
D. Ард түмэн E. Сонирхлоороо нэгдсэн бүлэг хүмүүс

16. Орчин үеийн нөхцөлд аль хэм хэмжээг зөрчсөнөөр илүү түгээмэл шийтгэлд өртөх вэ? (1 оноо)
A. Тэнгэр бурхныг дээдлэх B. Эх эцгээ дээдлэх C. Хуулийг дээдлэх
D. Үр хүүхдээ дээдлэх E. Багшаа хүндлэх

17. Иргэнийг түр хугацаагаар хооллох, эсвэл түүнд наад захын хувцас, хүнс болон ахуйн, соёлын зарим зүйлд хөнгөлөлт үзүүлэх, мэргэжил эзэмшүүлэх зэрэг төрөөс үзүүлэх үйлчилгээг юу гэдэг вэ? (1 оноо)
A. Нийгмийн эмзэг бүлэг B. Нийгмийн халамжийн үйлчилгээ
C. Нийгмийн асрамжийн үйлчилгээ D. Ядуурал
E. Төрийн ядууст зориулсан үйлчилгээ

18. Өрх гэр бүлийн хүрээнд аж ахуй оршин байх нийгэм бол…………….. (1 оноо)
A. Уламжлалт нийгэм B. Орчин үеийн нийгэм
C. Орчин үеийн дараах нийгэм D. Нэн орчин үеийн нийгэм
E. Аль нь ч биш

19. Нийгмийн гишүүдийн хоорондох шаталсан тэгш бус байдлын бүтцийг илэрхийлдэг ухагдахууныг………………гэнэ. (1 оноо)
A. Нийгмийн давхраажилт B. Дархлах, дархлагдах ёс
C. Албан тушаалын ялгаа D. Нийгэмд эзэлж буй байр суурь
E. Нийгмийн ялгарал

20. Нийгэм дэх улс төрийн харилцаа засаглалыг хэрэгжүүлж буй арга хэлбэр, голлох үзэл суртал, улс төрийн соёл, төр нийгмийн хоорондын харилцан хамаарлын шинж байдлыг…………хэлнэ. (1 оноо)
A. Улс төр B. Улс төрийн дэглэм
C. Улс төрийн засаглал D. Улс төрийн соёл
E. Улс төрийн харилцаа

21. Улс төрийн нам ба сонирхлын бүлгийн хоорондын ялгаа нь юу вэ? (1 оноо)
A. Зорилгын ялгаа B. Гишүүдийн тоо C. Хөрөнгө мөнгөний хэмжээ
D. Бүтцийн ялгаа E. Ангиллын ялгаа

22. Дараах тодорхойлолтуудаас аль нь төрийг хамгийн зөв тодорхойлсон тодорхойлолт вэ? (2 оноо)
A. Төр бол дарлагч ангийн ноёрхлын зэвсэг мөн
B. Төр бол нийгмийн бүлгүүдийн сайн сайхны төлөөх байгууллага юм
C. Төр бол ашгийн төлөөх улс төрийн байгууллага юм
D. Төр бол тодорхой хил хязгаар бүхий нутаг дэвсгэр дээр засаглалын дээд эрх мэдлтийг эдэлдэг нийгмийн улс төрийн байгууллага юм
E. Төр бол олон нийтийн байгууллага юм

23. Нийгэм дэх эдийн засгийн тасралтгүй үргэлжлэх үйл явцуудыг зөв дараалалд оруул. (2 оноо)
A. Хэрэглээ- Үйлдвэрлэл- Арилжаа- Хувиарлалт
B. Хувиарлалт- Хэрэглээ- Үйлдвэрлэл- Арилжаа
C. Үйлдвэрлэл- Арилжаа- Хувиарлалт- Хэрэглээ
D. Үйлдвэрлэл- Хувиарлалт- Арилжаа- Хэрэглээ
E. Арилжаа- Хэрэглээ- Хувиарлалт- Үйлдвэрлэл

24. Эдийн засаг дахь пүүсүүд өрх гэрүүдийн хэрэгцээг бүрэн хангаж чадахгүйн улмаас төгрөгийн ханш унасан бол инфляцийн шалтгааныг ол. (2 оноо)
    A. Зардлаас үүдэлтэй инфляци
    B. Эрэлтээс үүдэлтэй инфляци
    C. Зохисгүй инфляци
    D. Зохиомол инфляци
    E. Хэвийн инфляци
25. Доорхи өгөгдлийг зөв тохируул. (3 оноо)
    1. Борлуулалтын өрсөлдөөн
    2. Үнийн өрсөлдөөн
    3. Технологийн өрсөлдөөн
    4. Эрэлт бий болгох чадварын өрсөлдөөн

    a. Шинэ техник, технологи
    в. Реклам сурталчилгаа
    c. Зах зээлд үйлдвэрлэгчийн жин
    d. Хямд үнэтэй чанартай бүтээгдэхүүн

    A. 1a 2b 3c 4d
    B. 1c 2d 3a 4b
    C. 1c 2b 3a 4d
    D. 1a 2d 3c 4b
    E. 1a 2c 3d 4b
26. Оюуны соёлд хамааралгүй өгөгдлийг ол. (1 оноо)
    A. Эрдэм шинжилгээний хүрээлэн
    B. Сургууль
    C. Театр
    D. Номын сан
    E. Аль нь ч биш
27. Бусдыг өөрийн эрдэм мэдлэг, ур ухаан, авъяас чадвараараа араасаа дагуулах нь удидагчийн юу вэ? (1 оноо)
    A. Харизм
    B. Дарангуйлал
    C. Довтолгоон
    D. Давшилт
    E. Түрэмгийлэл
28. Нээлттэй нийгэмд хувь хүний давхраажилтад эзлэх статус нь аль нь вэ? (1 оноо)
    A. Эцэг эх ямар давхраанд харьялагдаж байгаагаар нь тодорхойлогдоно
    B. Насны статусаас бүрэн хамаарна
    C. Хувийн хичээл зүтгэл, чадвараас хамаарна
    D. Хүйс хийгээд арьс өнгөний статусаас хамаарна
    E. Аль давхраанд төрснөөс хамаарна
29. Нийгмийн эмзэг бүлэг хэмээх ойлголтыг тодорхойлоход аль нь илүүц вэ? (1 оноо)
    A. Бие даан амьдрах чадваргүй
    B. Хувираа хөдөлмөр эрхлэгч
    C. Тэжээн тэтгэх төрөл садангүй
    D. Ганц бие ахмад настан
    E. Аль нь ч биш
30. Монгол улсын иргэн Ариунаа захиргааны хариуцлагын хуулийн нэг зүйл заалт нь МУ-ын Үндсэн хуулийг зөрчсөн тул үүнийг зохих журмаар нь шийдвэрлүүлэх талаар гомдол гаргажээ. Энэ өгөгдлийн гол санаа нь аль нь вэ? (2 оноо)
    A. Ардчилсан нийгэмд хүн бүр өргөдөл гомдол гаргах эрхтэй гэсэн санаа юм
    B. Энд ардчилсан нийгмийн гол шинжийн талаар авч үзсэн байна
    C. Монгол улсын Үндсэн хуулийн Цэц үндсэн хуулийг зөрчсөн гэсэн маргааныг нь зөвхөн иргэний гаргасан гомдлоор авч хэлэлцдэг гэсэн санаа юм
    D. Үндсэн хуулийн Цэц бол үндсэн хуулийн шүүх юм гэдэг санаа
    E. Монгол Улсын захиргааны хариуцлагын тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн зарим нэгэн санааг зөрчсөн байдаг
31. Багш, эмч нар цалингаа нэмүүлэх зорилгоор Үйлдвэрчний Эвлэлтэй хамтран ажил хаялт зохион байгуулсан нь Засгийн газрыг төрийн албан хаагчдын цалинг 20 хувь нэмэгдүүлэхэд хүргэв. Үүний үр дүнд боловсрол, эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаа хэвийн явагдаж эхэлсэн бол энэ нь улс төрийн системийн ямар үйлдэл вэ? (1оноо)
    A. Оролт
    B. Эргэх холбоо
    C. Хувиралт
    D. Гаралт
    E. Шийдвэр
32. Эрхзүйт ба социаль төрийн хэлбэрүүд нь өөр хоорондоо харилцан адилгүй шинж чанартай байдаг хэдий ч тэдгээрт байх нийтлэг шинж байдаг. Ямар шинжээр эдгээр төрийн хэлбэрүүд нь адил байдаг вэ? (1 оноо)
    A. Хоёулаа хувь хүний сайн сайхан байдлыг хангах зорилгод үйлчилдэг
    B. Хоёулаа дарангуйллыг хүлээн зөвшөөрдөг
    C. Ард түмнийг номхон хүлцэнгүй байхыг шаарддаг
    D. Хоёулаа бүх хүмүүсийг ажлын байраар хангахыг зорьдог
    E. Хоёулаа нийгмийн орлогыг дахин хуваарилж тэднийг нийгмийн эмзэг хэсгийнхэнд хуваарилах гэж зорьдог
33. Монгол Улсын ерөнхийлөгчид 45 нас хүрсэн сүүлийн 5-аас доошгүй жил эх орондоо амьдран суусан уугуул иргэнийг нэр дэвшүүлж дийлэнх олонхийн саналыг авсан нэр дэвшигч ерөнхийлөгчөөр сонгогдох эрхтэй болдог. Тэгвэл ерөнхийлөгчийн сонгуульд оролцон саналаа өгөх иргэн Дондог ямар шаардлагыг хангасан байх ёстой вэ? (1 оноо)

A. Сонгуулийн насанд хүрсэн
B. Өмч хөрөнгөтэй болсон байх
C. Сүүлийн 3 жил нэг хаяг дээр байнга оршин суусан байх
D. Ямар нэгэн намын гишүүн байх
E. Өөрийн өмчилж авсан газартай байх

34. Монгол Улсын иргэн Атарыг эх орондоо сүүлийн 5 жил амьдраагүй гэсэн үндэслэлээр сонгуульд оролцож саналаа өгөх эрхийг хассан байна. Хэрвээ та энэ тохиолдолд дээрх үндэслэл нь буруу гэдгийг юугаар батлах вэ? (2 оноо)
A. МУ-д сонгох эрхэд биш сонгогдох эрхэд ийм төрлийн хязгаарлалт байдаг
B. МУ бол ардчилсан улс болохоор хэн ч байсан сонгох сонгогдох эрхээ эдлэх ёстой
C. Түүний нэрийг сонгогчдын нэрсийн жагсаалтаас ийм үндэслэлээр хассан нь зөв юм
D. Энэ үндэслэлгээ зөв учраас би дэмжиж байна
E. Сонгох эрхийн хязгаарлалтад ийм төрлийн хязгаарлалтыг МУ-ын Үндсэн хуулиар оруулж өгсөн байдаг

35. Үнийн ялимгүй бага өөрчлөлт нь бүтээгдэхүүний тоо хэмжээнд асар их өөрчлөлт оруулсан бол эрэлтийн мэдрэмжийг тодорхойл. (2 оноо)
A. Сул мэдрэмжтэй эрэлт
B. Нэгж мэдрэмжтэй эрэлт
C. Мэдрэмжтэй эрэлт
D. Төгс мэдрэмжтэй эрэлт
E. Огт мэдрэмжгүй

36. Бензиний үнэ нэмэгдсэн бол зах зээлд ямар хандлага гарах вэ? (2 оноо)
A. Машины эрэлт буурна
B. Бензиний эрэлт ихсэнэ
C. Машины эрэлт өснө
D. Машины нийлүүлэлт нэмэгдэнэ
E. Бензин болон машины нийлүүлэлт нэмэгдэнэ

37. Аль нь эдийн засгийн талаарх үндсэн хуулийн заалт вэ? (1 оноо)
A. Монгол Улсад газар түүний хэвлий ой, ус,амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл төрийн хамгаалалтанд байна
B. Монгол улсын банкны тогтолцоо нь төв банк, арилжааны банкаас бүрдэнэ
C. Монгол улсын Нийгмийн хамгааллын тогтолцоо нь нийгмийн даатгал, нийгмийн халамжаас бүрдэнэ
D. Монгол улсын татваврын тогтолцоо нь албан татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ
E. Төсөв нь орон нутгийн болон улсын төсвөөс бүрдэнэ

38. Дорж техник технологийн дэвшлийн улмаас ажлаасаа халагдсан бол ажилгүйдлийн аль хэлбэрт хамаарах вэ? (1 оноо)
A. Бүтцийн
B. Мөчлөгийн
C. Завсрын
D. Шилжилтийн
E. Улирлын

39. Гэр бүлийн доторх хэв маяг, ханиа сонгох ёсыг зөв харгалзуул. (2 оноо)

| | |
|---|---|
| 1. Эцгийн эрхт ёс | a. Гэрлэлтийг тодорхой бүлгийн хүрээнд нь баталгаажуулдаг ёс |
| 2. Эхийн эрхт ёс | b. Гэрлэлтийг тодорхой бүлгээс нь үл хамааруулан зохицуулдаг ёс |
| 3. Экзогами ёс | c. Гэр бүлийн гишүүдийг эрэгтэй хүн удирдаж засаглах байдал |
| 4. Эндогами ёс | d. Гэр бүлийн засаглалын тогтолцоонд эхнэр юмуу эх голлон үүрэгтэй оролцох |

A. 1c 2d 3b 4a
B. 1a 2b 3c 4d
C. 1b 2c 3d 4a
D. 1c 2a 3b 4d
E. 1c 2b 3a 4b

40. Ухамсар сэтгэхүйн чанарууд тухайлбал зөгнөж мөрөөдөх, дурсан санах, дүгнэлт хийх гэх мэт нь хүний……………..юм. (1 оноо)
A. Биологийн мөн чанар
B. Нийгмийн мөн чанар
C. Оюуны мөн чанар
D. Байгалийн мөн чанар
E. Зөн совин

41. Улс төрийн соёл нь улс төрийн системтэй хэрхэн холбогддог вэ? (2 оноо)
A. Улс төрийн систем нь улс төрийн соёлынхоо дэд систем нь болдог
B. Улс төрийн соёл нь улс төрийн системийнхээ дэд систем нь болдог
C. Эдгээр 2 ойлголт нь өөр хоорондоо ямар ч харилцан хамааралгүй ойлголтууд юм
D. Дээрх хоёр ойлголтыг гуравдагч ойлголтын тусламжтайгаар тодорхойлж болох юм
E. Дээрх ойлголтууд нь агуулгын хувьд харилцан тэнцвэртэй ойлголтууд

42. Улс төрийн соёл нь улс төрийн ухамсраас юугаараа ялгаатай вэ? (2 оноо)
A. Улс төрийн соёл бол улс төрийн системтэй холбоотой ойлголт учраас улс төрийн ухамсраас ялгаатай
B. Улс төрийн соёл нь зөвхөн билэг тэмдгийн тогтолцоогоор илэрхийлэгддэгээрээ ялгаатай юм
C. Улс төрийн соёл нь улс төрийн үзэгдэл үйл явцын талаар хүмүүсийн ухамсарт гүн гүнзгий шингэж үйл ажиллагааных нь үндсэн хандлагыг тодорхойлдог үзэл бодол чиг баримжааг агуулж байдгаараа ялгаатай юм

D. Нийгмийн доторх олон янзын хэсэг бүлэг, янз бүрийн эрх ашиг бүхий хүчнүүдийг хооронд нь ойртуулан нягтруулж, төрийн нэгдмэл чанарыг хангаж байдгаараа ялгаатай юм
E. Энэ нэг ойлголтыг хоёр янзаар тайлбарласан боловч ижил утгатай юм

43. Бүтээгдэхүүний үнэ өсөхөд эрэлтийн тоо хэмжээ буурах, бүтээгдэхүүний үнэ буурахад эрэлтийн тоо хэмжээ өсөх зүй тогтлыг эрэлтийн хууль гэх бөгөөд үүнийг эрэлтийн муруйгаар илэрхийлнэ үү? (2 оноо)




44. Хэрвээ бүтээгдэхүүний үнэ 20000 төгрөгөөр тогтсон бол зах зээлд ямар үзэгдэл болох вэ? (3 оноо)

A. Илүүдэл нийлүүлэлт
B. Илүүдэл эрэлт
C. Барааны хомсдол
D. Эрэлт нийлүүлэлтийн тэнцвэр
E. AB хариулт зөв




45. Монголчуудын дэлхийн соёлын өвд бүртгүүлсэн морин хуур, тэрчлэн хөөмий, уртын дуу, биелгээ зэрэг нь ардын соёлын сонгодог бүтээл мөн. (1 оноо)
A. Ардын соёл B. Нийтийн соёл C. Элитийн соёл
D. Дэд соёл E. Сонгодог соёл

46. Соёлын элементэд аль нь хамааралгүй вэ? (1 оноо)
A. Үнэт зүйлс B. Билэг тэмдэг
C. Хэм хэмжээ D. Итгэл үнэмшил E. Дасан зохицол

47. Сүүлийн үед хүний наймааны тухай их ярих болжээ. Хүний наймаа нь зэвсэг, хар тамхины дараа орох хууль бус бизнесийн нэг төрөл болсон нь дэлхий нийт тэр дундаа ядуу буурай улсуудын хувьд хамгийн өндөр эрсдэлтэй орны тоонд багтдаг. Хүний наймаа гэдэг ойлголт доорх өгөгдлийн алинд багтах вэ? (2 оноо)
A. Үндэстэн дамнасан гэмт хэрэг
B. Улс орны эдийн засгийг хүндрэлд оруулах хүчин зүйл
C. Хүний нийгмийн хөгжил
D. Гэр бүл салалтын шалтгаан
E. Дээрх бүгд

48. Ямар институт нь нийгмийн эв нэгдэл, зөвшилцлийг тогтоох чиг үүргийг хүлээдэг вэ? (1 оноо)
A. Улс төрийн институт B. Гэр бүлийн институт
C. Боловсролын институт D. Эдийн засгийн институт
E. Шашны институт

49. Нэр томъёо, ойлголтуудын зөв харгалзааг тогтооно уу? (2 оноо)

| | |
|---|---|
| 1. Либерал ардчилсан дэглэм | a. Нийтийн сайн сайхан үндэсний уламжлалт үнэт зүйлийг хамгаалах үүднээс төрийн хууль ёсны оролцоо зохицуулалтыг харьцангуй өндөр түвшинд хадгална |
| 2. Охлократ ардчилсан дэглэм | b. Хуулиар хориглоогүй бүхнийг зөвшөөрнө |
| 3. Консерватив ардчилсан дэглэм | c. Ардчиллын үнэт зүйлсийг ард түмний дуу хоолой, шахалтаар хэрэгжүүлдэг. |

A. 1b 2c 3a B. 1a 2b 3c C. 1c 2a 3b
D. 1b 2a 3c E. Зөв хариулт алга

50. Судалгаандаа түүврийн аргыг ашиглахаар шийдсэн бол аль сонголт зөв бэ? (2 оноо)
A. Ангийн нийт сурагчдыг хамруулна B. Анги бүрээс 5 хүүхэд авна
C. Анкетаар нийт сурагчдаас асуулга авна. D. Нээлттэй асуулгын аргаар судлагаа хийх
E. Дээрх бүгд зөв

51. Улс төрийн систем гэдэг нь улс төрийн шалтгаан үр дагавраар холбогдсон дэс дараалсан системлэг үйлдлүүдийн цогц бол улс төрийн системийн талаарх зөв бодомжийг олно уу? (2 оноо)

A. Оролт- гаралт- эргэх холбоо- хувиралт
B. Хувиралт- оролт- эргэх холбоо- гаралт
C. Эргэх холбоо- оролт- гаралт-хувиралт
D. Оролт- хувиралт- гаралт- эргэх холбоо
E. Гаралт- оролт- эргэх холбоо- хувиралт

52. Инфляцийн улмаас Монгол банкнаас бодлогын хүүгээ нэмэгдүүлсэн явдал нь ямар ач холбогдолтой вэ? (2 оноо)
A. Жижиг дунд үйлдвэрлэгчид зээл авахаас халширах болсон
B. Арилжааны банкууд ашиг олох боломжтой болсон
C. Төгрөгийн өртөгийг нэмэгдүүлэх гарц болсон
D. Монгол банкинд төвлөрөх мөнгөн хөрөнгийг нэмэгдүүлсэн
E. Хувьцаат компаниудад бонд гаргаж зарах боломжийг бүрдүүлсэн

53. Таны бодлоор эдийн засгийн хямралыг багасгах талаар засгийн газраас авах нэн тэргүүний арга хэмжээ аль нь вэ? (3 оноо)
A. Татварын хувийг багасгаж цалин нэмэгдүүлэх
B. Ажлын байр бий болгох замаар үндэсний үйлдвэрлэлээ дэмжих
C. Доллартай харьцах төгрөгийн ханшийг өсгөх
D. Нийгмийн шат бүрд илүүдэл хэрэглээг багасгаж, зардлыг бууруулах
E. Хандивын сан бүрдүүлэх

54. Өдөр тутмын гүйлгээнд гадаад валют ашиглах нь нийгэмд ямар нөлөөтэй гэж бодож байна вэ? (2 оноо)
A. Худалдаа эрхлэгчид гадаад валюттай шууд харилцах сайн талтай
B. Олон орны мөнгөн тэмдэгтийг ашиглах нь төгрөгийн өртгийг нэмэгдүүлдэг
C. Төгрөгийн өөрийн өртөг буурч инфляци өсөх аюултай
D. Боломжтой бол гадаад валютийг зах зээлд хэрэглэх хэрэгтэй
E. Яваандаа гадаадын брендүүд Монголын зах зээл дээр хямдхан зарагдах болно

55. Дэлхийн талыг байлдан дагуулж байсан Эзэнт гүрний үед ч хөрш орнуудтай элч илгээх, бичиг захидал солилцох, худалдаа наймаа хийх, худ ураг бололцох, найрамдах, дайтах зэргээр харилцаж ирсэн. Чухам энэ үеэс эхлэн Монгол улсын гадаад харилцаанб үндсэн чиглэл хөгжсөн гэж үздэг. Дээрх нь ямар бодлого вэ? (2 оноо)
A. Хэн хүчтэй бол түүний зөв гэсэн дайнч бодлого
B. Бусад үндэстэнг эрхшээлдээ оруулах дайнч бодлого
C. Энхийг эрхэмлэсэн шинжтэй бодлого
D. Бусдын хамгаалал нөлөөнд орж хараат байх бодлого
E. Бусдыг аялдан дагах бодлого

56. Долларын үнийн өсөлт Монголын эдийн засагт хэрхэн нөлөөлсөн гэж бодож байна (3 оноо)
A. Мөнгөний ханшийг бууруулж төгрөгийг үнэгүйдүүлсэн
B. Бусад гадаадын валютын үнийг өсгөсөн
C. Ажилгүйдлийг ихэсгэсэн
D. Долларын хадгаламж эзэмшигчдэд ашиг оруулсан
E. Аль нь ч биш

57. Албан хэм хэмжээг олно уу. (2 оноо)
A. Улсын наадмын их насны морьд гарааны зурхайгаас эргэлээ
B. Цүнхтэй их хэмжээний мөнгө, үнэт зүйл олсон хүн цагдаагийн байгууллагад хандав
C. МУ-ын Үндсэн хуулинд иргэний эрх үүргийг заасан байдаг
D. Ах нь сургаж, дүү нь сонсдог
E. Хүн ахтай, дээл захтай

## ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1. Дэлхийн олон улсын харилцааны бодлого туйлуудыг тохирох дүрмүүдтэй нь зөв харгалзуулна уу? (5 оноо)

| | | | |
|---|---|---|---|
| 1. | Нэг туйлт | A. | 1. Нөгөө хоёр талтай аль алинтай нь сайн харилцаатай байх, зөрчил үүсэхээс болгоомжлох<br>2. Нөгөө 2 талын хооронд ойр дотны хамтын ажиллагаа бий болохоос сэргийлэх явдал |

| | | | |
|---|---|---|---|
| 2. | Хоёр туйлт | B. | 1. Ноёрхогч шинжтэй бий болж буй аливаа улс, эвслийг эсэргүүцэх<br>2. Хүчээ аль болгох ихэсгэх, эсвэл хадгалах<br>3. Аль нэг талтай дайтсан ч системийг бүхэлд нь тогтворжуулах хэрэггүй |
| 3. | Гурван туйлт | C. | 1. Нэг эвсэлтэй тэмцэлдэх, боломжтой бол устгахыг оролдох<br>2. Өөрийн хүчийг байнга нэмэгдүүлэхийг оролддог, нөгөө эвсэлийн гишүүнийг өөртөө татах, өөрөөсөө гишүүнээ алдахгүй байх гэх мэт тактик ашиглана |
| 4. | Олон туйлт | D. | 1. Цөм их гүрэн нь үндсэн дүрэм зарчмыг тогтоон хэрэгжүүлж, цэрэг эдийн засгийн хувьд ноёрхоно<br>2. Өөрийн нөлөөнд буй нэгжүүдийн хоорондын зөрчилдөөнийг зохицуулна<br>3. Нэгж улсуудыг тусгаарлах, бие даах оролдлогыг таслан зогсоох |
| 5. | Цөөн туйлт | E. | 1. Олон улсын харилцаан дахь онолын ойлголт биш |

2.2. Дараах бодомжуудыг зөв харгалзуулна уу? (5 оноо)

| | | | |
|---|---|---|---|
| 1. | Сонгох эрхийн хязгаарлалт | A. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль |
| 2. | Сонгогдох эрхийн хязгаарлалт | B. | Балт нь сэтгэцийн өвчтэй нь шүүх эмнэлэгээр тогтоогдсон |
| 3. | Хууль тогтоох байгууллага | C. | Хууль батлах |
| 4. | Монгол Улсын Засгийн газар | D. | Болдоо нь сонгуульд оролцож ах шигээ саналаа өгөхийг хүссэн ч энэ боломжгүй юм. Учир нь тэр 18 нас хүрээгүй |
| 5. | Сонгуулийн эрх зүйн хэм хэмжээ | E. | Төрийн гүйцэтгэх дээд байгууллага юм |

2.3. Хүний мэдлэгийн тогтолцоонд гарах ахиц дэвшил, өөрчлөлтүүдтэй уялдаад оршин амьдарч буй нийгмийн талаар өгсөн тодорхойлолт, хандлагуудад хүртэл өөрчлөлт орж байдаг. Тиймээс дараах өгөгдлүүдийг зөв харгалзуулаарай. (5 оноо)

| | | | |
|---|---|---|---|
| 1. | К. Маркс | A. | Нийгэм гэдэг бол бусад хүмүүсийн болон үйл явдалд хандсан нийгмийн бүтээгдэхүүн болдог хүмүүсийн харилцан үйлчлэл юм |
| 2. | М. Вебер | B. | Нийгмийг бүрдүүлэгч дэд тогтолцоонуудад нь тус бүрдээ бие даан орших боломжгүй бөгөөд харилцан бие биенийхээ хамааралд оршдог |
| 3. | Т. Парсонс | C. | Нийгэм гэдэг бол нягт хэлхээ холбоонд оршдог элементүүдийн нийтлэг тогтолцоо юм |
| 4. | Тогтолцооны хандлага | D. | Нийгэм гэдэг бол холбогч эхлэлийн цэг нь хэм хэмжээ ба үнэт зүйлс байдаг хүмүүсийн хоорондын харилцааны цогц юм |
| 5. | Шалтгаант чанарын хандлага | E. | Нийгэм гэдэг бол хамтын ажиллагааны үйл явцад бүрэлдсэн хүмүүсийн хоорондын харилцааны түүхэн ёсоор хөгжигч юм |

## ХУВИЛБАР D

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Нийлмэл нийгмийн шинжид хамааралгүй зүйлийг дугуйлна уу. (1 оноо)
   A. Хүмүүсийн хоорондын олон янзын тогтвортой өргөн холбоо
   B. Нийгэмд эд хөрөнгийн ялгаа гараагүй
   C. Нийгмийн ялгарал
   D. Төр засаг, эрх мэдлийн ялгаа бий болсон
   E. Хамааралгүй зүйл дурдаагүй байна.
2. Урьдчилан бэлтгэсэн асуулт, хариулт бүхий хуудсаар мэдээлэл цуглуулах аргыг юу гэдэг вэ? (1 оноо)
   A. Ярилцлага  B. Анкет буюу асуулга  C. Ажиглалт
   D. Туршилтын арга  E. Эдгээрээс өөр
3. Ажиглалтын аргыг аль нь тодорхойлж байна вэ? (1 оноо)
   A. Үзэгдлийг мэдрэхүйгээрээ танин мэдэхүй
   B. Үзэгдлийг тодорхой зорилготойгоор мэдрэхүйгээр дамжуулан сэтгэхүйн түвшинд танин мэдэхүй
   C. Тухайн үзэгдлийн байдлыг тандан харзнахуй

D. Үзэгдлийг тодорхой бус зорилготойгоор дамжуулах
E. Аль нь ч биш

4. МУ-ын төрийн далбааны аль хэсэгт нь алтан соёмбыг байрлуулдаг вэ? (1 оноо)
   A. Далбааны гол хэсэгт
   B. Далбааны шар дэвсгэрийн голд
   C. Далбааны улаан дэвсгэрийн голд
   D. Далбааны ишин талын улаан дэвсгэрийн голд
   E. МУ-ын төрийн далбаан дээр соёмбо байдаггүй
5. Төрийн хөгжлийн аль үе шатанд хүмүүсийн нийтлэг зөвхөн цусан төрлийн холбоон дээр суурилахаа больж нутаг дэвсгэр угсаатны нийтлэгүүд бий болон улмаар эрх мэдлийн эх сурвалж нь зөвхөн удирдагчийн онцгой авъяас чадвар байхаа больж уламжлах, үе залгамжлах ёс зэрэг өөр хүчин зүйлээр тодорхойлогдох болсон бэ? (1 оноо)
   A. Хөгжлийн эхэн үе
   B. Эртний Грек, Ромоос дундад зууныг дуусах хүртэлх үе
   C. Орчин үед
   D. Хүй нэгдлийн байгууллын үед
   E. Овгийн байгууллын үед
6. Эрх мэдлийн мөн чанарыг тодорхойлох нэг гол ойлголт бол хүсэл зориг юм. Тэрхүү хүсэл зоригийг илэрхийлэх үндсэн арга болох албадах ба итгүүлэх аргын аль нь хүсэл зоригоо илэрхийлж биелүүлэх хамгийн үр бүтээлч чанартай вэ? (1 оноо)
   A. Итгүүлэх арга нь
   B. Хүчирхийлэх арга нь
   C. Аль нь ч биш
   D. Үр бүтээлч чанарын хувьд нэг нь нөгөөгөөсөө давуу байх боломжгүй юм
   E. Заналхийлэх арга
7. Улс төрөөс бусдыг зөвшөөрнө гэсэн уриаг аль дэглэмийн үед баримталдаг вэ? (1 оноо)
   A. Улс төрийн ардчилсан тогтолцооны үед    B. Тоталитар дэглэмийн үед
   C. Авторитар дэглэмийн үед    D. Охлократ дэглэмийн үед
   E. Аль нь ч биш
8. Давхраажилтын үндсэн хэв шинжийг тохируул. (3 оноо)

| | | | |
|---|---|---|---|
| 1. | Боолын | a. | Манугийн хууль |
| 2. | Кастын | b. | Тэгш бус байдал |
| 3. | Анги бүлгийн | c. | Өв залгамжлал |
| 4. | Язгуур угсааны | d. | Боолын хүү, боол |

   A. 1d 2a 3b 4c    B. 1a 2d 3b 4c    C. 1b 2c 3a 4d
   D. 1c 2b 3d 4a    E. 1a 2b 3d 4b
9. Өгөгдлийг уншаад эдийн засгийн үндсэн асуудлыг сонгоно уу. (1 оноо)
   A. Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээний асуудал
   B. Бизнесүүдийн хоорондын өрсөлдөөнийг
   C. Нөөц баялгийн үйлдвэрлэлийг
   D. Юуг яаж хэнд зориулан үйлдвэрлэхийг
   E. Бараа бүтээгдэхүүн ба үйлчилгээний хуваарилалтыг
10. Зах зээлд оролцогч үндсэн субъектүүдийг дурьдахад илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? (1 оноо)
   A. ҮНБ    B. ҮЦБ    C.ҮО
   D. ДНБ    E. Эдийн засгийн өсөлт
11. Мөнгөний бодлого гэж юу вэ? (1 оноо)
   A. Мөнгөн тэмдэгт гүйлгээнд оруулах
   B. Банк хоорондын төлбөр тооцоог зохицуулах
   C. Арилжааны банкны үйл ажиллагаанд хяналт тавих
   D. Эдийн засаг дахь мөнгөний нийт тоонд болон тэдгээрийг тавьж олгох өртөгт нөлөөлөх
   E. Гадаад валютын улсын нөөцийг зохицуулах
12. Бөөний үнэ дээр борлуулалтын зардал болон ашгийг нэмсэн нь ямар үнэ вэ? (1 оноо)
   A. Үйлдвэрлэлийн үнэ    B. Жижиглэнгийн үнэ    C. Үнэмлэхүй үнэ
   D. Эдгээрээс өөр    E. Бүх хариулт буруу
13. Аливаа үндэсний соёл нь дотроо олон хувилбартай, нэгэн төрөл биш байдалтай байхын хамт үндэсний соёл нь хүн төрөлхтний соёлтой харьцуулахад ялгаа гардаг. Үүнийг………..гэнэ. (1 оноо)
   A. Соёлын олон талт байдал    B. Соёлын түгээмэл шинж    C. Соёлын зөрчилт байдал
   D. Соёлын хэм хэмжээ    E. Соёлын хэлбэр

14. Дараах өгөгдлийг уншаад шашны нийгмийн ямар үүрэг болохыг тодорхойлно уу? Шашин нь: Иргэний хуулийн нэгэн адил хүмүүсийг дэг журамтай,ёс суртахуунтай, хөдөлмөрийг шүтдэг иргэд болгон хүмүүжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл нийгмийн гишүүдийн үйл байдлын хэм хэмжээг зохицуулдаг гэдэг үзэл нь ... (1 оноо)
   A. Үнэт зүйлийн үүрэг B.зохицуулах болон хэм хэмжээний үүрэг
   C. Ертөнцийг үзэх үзлийн үүрэг D. Хүмүүсийг нэгтгэх туслалцаа үзүүлэх үүрэг
   E. Ямар нэгэн зүйлд итгэн шүтэх боломжийг олгох
15. 1992 онд шинэ үндсэн хуулиа баталгаажуулав. Ингэснээр Монгол улс дэлхий дахинд нээлттэй болж, хүн төрөлхтөний хөгжлийн нийтлэг чиг хандлагаар замнах таатай нөхцөл бүрдсэн. Монгол улсын гадаад бодлогод таатай нөхцөл болж буй хүчин зүйлс юу вэ? (1 оноо)
   A.Үндсэрхэг үзэл дахин сэргэсэн
   B. Дэлхийн улс түмнүүд ойртон нягтарч байгаа
   C. Нийгэм-эдийн засгийн дотоод өөрчлөлт, шинэчлэлт
   D. Дээрх хариулт бүгд зөв
   E. A ба C хариулт зөв
16. НҮБ-ын албан ёсны хэл юу вэ? (2 оноо)
   A. Араб, Англи, Хятад, Франц, Орос, Испани B. Англи, Орос
   C. Хятад, Араб, Испани, Англи D. Япон, Хятад, Англи, Орос, Солонгос
   E. Хятад, Араб
17. Нийгмийн үйл хэрэгт идэвхитэй, ухамсартай оролцож, нийгмийн хэм хэмжээг даган баримталдаг хүнийг философид юу гэж нэрлэдэг вэ? (1 оноо)
   A. Хүн B. Бие хүн C. Бодгаль хүн
   D. Энэ гурваас өөр хүн E. Гэгээрсэн хүн
18. Нийгмийн давхраажилтын хэмжигдэхүүнд үл хамаарах зүйл дурдсан бол аль нь вэ? (1 оноо)
   A. Эд баялаг B. Эрх мэдэл
   C. Нэр хүнд D. Боловсрол E. Гэрлэлт
19. Эртний нэгэн сэтгэгч "Миний төр намайг хамгаална" гэж хэлсэн байдаг. Тэгвэл энэ нь төрийн хувьд дараах үүргүүдийн алинд нь хамаарах вэ? (1 оноо)
   A. Хүлээсэн үүрэг B. Социаль үүрэг C. Зайлшгүй үүрэг
   D. Төрийн ёс зүйн асуудал E. Заяагдмал үүрэг
20.

| <u>Орлого</u> | <u>Татвар</u> |
|---|---|
| 100.000 төгрөг | 5000 төгрөг |
| 200.000 төгрөг | 20.000 төгрөг |

   Дээрхи татварыг…………………гэнэ. (2 оноо)
   A. Өсгөн нэмэгдүүлэх татвар B. Өсгөн бууруулах татвар
   C. Хувь тэнцүүлсэн татвар D. Нэмүү өртгийн татвар
   E. Онцгой албан татвар
21. Эдийн засгийн сэтгэлгээний түүхэн дэх баялгийн тухай ойлголтыг зөв харгалзуул. (4 оноо)
   1. Меркантализм а. Гүйлгээний хүрээн дэх мөнгө бол үндэсний баялаг
   2. Физиократууд б. Ашиг хонжоо хайсан үйл ажиллагаа нь эцсийн дүнд баялгийг бүтээдэг
   3. Сонгодог онол в. ХАА, газар тариалангийн бүтээгдэхүүн жинхэнэ баялаг
   4. Шинэ сонгодог г. Ажилчны бүтээсэн хөлсний хөдөлмөрийг капиталист мөлжих замаар ашгийг бүтээдэг
   A. 1а 2б 3в 4г B. 1а 2в 3б 4г C. 1г 2б 3в 4а
   D. 1в 2б 3а 4г E. 1г 2а 3в 4б
22. Зах зээлийн харилцаа эдийн засгийн үндсэн үйл явцуудын алин дээр нь илэрдэг вэ? (1 оноо)
   A. Үйлдвэрлэлт B. Хувиарлалт C. Арилжаа
   D. Хэрэглээ E. Түгээлт
23. Цэгийн оронд тохирох үгийг ол. Хүний хангагдаагүй хүслийг..……….гэнэ. (1 оноо)
   A. Нөөц B. Эрэлт C. Өртөг
   D. Хэрэгцээ E. Хүсэл
24. Эдийн засгийн тогтолцооны төрлүүдийг түүхэн үетэй нь зөв харгалзуулна уу. (3 оноо)
   1. Уламжлалт эдийн засгийн тогтолцоо а. Богд хаант Монгол улс
   2. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоо б. Монгол улс
   3. Зах зээлийн эдийн засгийн тогтолцоо в. БНМАУ
   A. 1а 2б 3в B. 1а 2в 3б C. 1б 2а 3в
   D. 1в 2б 3а E. 1б 2в 3а

25. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу. (2 оноо)

| | |
|---|---|
| 1. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага | A. Хүүхдийн хөдөлмөрийг зогсоох үндсэн зорилготой байгууллага |
| 2. Хүний эрхийн дээд комиссарын газар | B. Валют, мөнгөний асуудлаар олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын худалдааны тэнцвэртэй өсөлтийг дэмжих, засгийн газрын төлбөрийн чадварын алдагдлыг залруулахад туслах зорилготой |
| 3. Олон улсын валютын сан | C. Олон улсын хэмжээнд хүн төрөлхтний Эрүүл мэндийн асуудлыг хариуцан зохицуулж, шийдвэрлэх үүрэг бүхий засгийн газар хоорондын байгууллага |
| 4. Олон улсын хөдөлмөрийн байгууллага | D. Бүх нийтийн хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн хамгаалах зорилго бүхий байгууллага |

26. Бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудыг зөв харгалзуул. (4 оноо)

| | |
|---|---|
| 1. Европын холбоо | a. Ази, Европын орнуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх байгууллага |
| 2. Зүүн өмнөд азийн орнуудын холбоо /АСЕАН/ | b. Европ тивийн улс түмний нягт холбоог бий болгох, эдийн засгийн тэнцэлтэй байнгын дэвшилд дөхөм үзүүлэх, гадаад болон аюулгүй байдалд нийцсэн бодлого явуулж олон улсын харилцаанд Европын нэгдмэл шинж чанарыг бататгах, нийтлэг өв уламжлалыг хадгалан бэхжүүлэх зорилго бүхий байгууллага |
| 3. Ази, Номхон далайн Эдийн засгийн хамтын ажиллагааны чуулга /АПЕК/ | c. Зүүн өмнөд Азийн эдийн засаг, нийгэм, соёлын салбарт хамтын ажиллагааг зохион байгуулах, энх тайван тогтвортой байдлыг буй болгоход дөхөм үзүүлэх зорилготой байгууллага |
| 4. Ази- Европын уулзалт /АСЕМ/ | d. Ази, Номхон далайн бүсэд олон талын чөлөөт худалдааны хөрөнгө оруулалтын нээлттэй зах зээл бий болгоход дөхөм үзүүлэх зорилготой байгууллага |

A. 1b 2c 3d 4a　B. 1b 2a 3d 4c　C. 1c 2d 3a 4b
D. 1d 2a 3b 4c　E. 1c 2d 3b 4a

27. Аль нь төрөлх статус вэ? (1 оноо)
A. Миний ээж буриад ястан　B. Ах маань оюутан болсон
C. Дорж хуульч хийж байгаа　D. Миний дүү 6 нас хүрч сургуульд оров
E. Боксчин Бадар-Ууган хөдөлмөрийн баатар боллоо.

28. Холбогдох хуулийн үүднээс өндөр насны тэтгэврийн даатгал нь аль хэлбэрт хамаарах вэ? (1 оноо)
A. Заавал даатгуулах　B. Сайн дурын даатгал
C. Аль нь ч байж болдог　D. Хуулинд энэ тухай заалт байхгүй
E. Индексжүүлсэн даатгал

29. Иргэдийнхээ тэр дундаа эмзэг бүлгийнхний нийгмийн нөхцөл байдлыг сайжруулах, эрсдэлд өртүүлэхгүйн тулд төрөөс цогц арга хэмжээ авч хэрэгжүүлдэг. Энэ ямар арга хэмжээ вэ? (1 оноо)
A. Нийгмийн хамгаалал　B. Нийгмийн даатгал
C. Нийгмийн халамж　D. Хадгаламжийн тэтгэмж
E. Эмзэг бүлгийнхэнд зориулсан тэтгэмж

30. Бид бүгдээрээ УИХ-ийн гишүүн болох боломжгүй. Гэтэл бид багийн нийтийн хуралд оролцон өөрсдийн санаа бодлоо илэрхийлэн баг хорооныхоо холбоотой асуудлаа шийдвэр гаргахад биечлэн оролцох боломжоор хангагдсан байдаг. Тэгвэл энд ардчиллын ямар хэлбэр ажиглагдаж байна вэ? (2 оноо)
A. Шууд ардчилал　B. Шууд бус ардчилал
C. Чөлөөт ардчилал　D. Хагас ардчилал
E. Хагас- чөлөөт ардчилал

31. Дараах бодомжуудаас аль нь ардчиллын үнэт зүйлс эрхэмлэлд харшилж байна вэ? (2 оноо)
A. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа 4 жил байх бөгөөд энэхүү бүрэн эрхээ зөвхөн 1 удаа л улируулан эдэлж болно. Гэхдээ энэ ардчилсан сонгууль явагдахгүй гэсэн үг биш юм
B. Өөрийн гэсэн эд хөрөнгөтэй, эзэмшил газар нутагтай иргэд л сонгуульд оролцох эрхтэй
C. Иргэд саналаа нууцаар өгнө
D. Засгийн бүх эрх ард түмний гарт байна
E. Нийгмийн бүх гишүүд хууль шүүхийн өмнө тэгш эрхтэй байна

32. Нийгмийн давхраажилтын үндсэн хэмжигдэхүүнүүдийг зөв харгалзуулна уу. (2 оноо)

| | | | |
|---|---|---|---|
| 1. | Орлого | a. | Хууль зүйн ухааны бакалавр зэрэгтэй тохиолдолд хууль зүйн ухааны докторын зэргийг 3 жил суралцаад хамгаалах эрхтэй |
| 2. | Боловсрол | b. | УИХ-ын гишүүн хууль санаачлах эрхтэй |
| 3. | Эрх мэдэл | c. | Компанийн захирлын сарын цалин 5 000 000 төгрөг |
| 4. | Нэр хүнд | d. | Үндэсний бөхийн арслан цолтой хүн эрэмбээрээ аварга цолтой хүний доод талд сууна |

A. 1c 2a 3b 4d B. 1a 2c 3b 4d C. 1d 2b 3a 4c
D. 1c 2d 3b 4a E. 1b 2a 3c 4d

33. Эдийн засагт инфляци бий болох хандлагатай бол зөв сонголт аль нь вэ? (1 оноо)
A. Мөнгөө банкинд хадгалуулах B. Мөнгөөрөө байр худалдаж авах
C. Мөнгөө гэртээ хадгалах D. Хувьцаа худалдаж авах
E. Мөнгөө зээлдүүлэх

34. Аль нотолгоо нь үнэн бэ? (2 оноо)
A. Арилжааны банк хүүгийн бодлого авч явуулдаг
B. Төв банк мөнгөн хадгаламж хүлээж авдаг
C. Арилжааны банк, банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулдаг
D. Төв банк гадаад валютын улсын нөөцийг эзэмшиж зохицуулах үүрэг хүлээж байдаг
E. Эдгээр ойлголт бүгд буруу

35. Монгол улсад гадаадаас оруулж ирж байгаа архи, тамхи зэрэг зарим барааны хэрэглээг хязгаалах зорилгоор зохицуулалт хийдэг. Тэгвэл энэ нь татварын ямар төрөлд багтах вэ? (1 оноо)
A. Орлогын албан татвар B. Хөрөнгийн албан татьар
C. Онцгой албан татвар D. Гаалийн албан татвар
E. Шууд бус албан татвар

36. Инфляци үүсэх шалтгаанд аль нь үл хамаарах вэ? (1 оноо)
A. Бараа бүтээгдэхүүний үнэ өссөн
B. Ажилчдын цалин хөлс үндэслэлгүй нэмэгдсэн
C. Хүн амын худалдан авах чадвар муудсан
D. Мэдээллийн хомсдол бий болсон
E. Бараа бүтээгдэхүүний хомсдол бий болсон

37. Техник технологийн шинэчлэлийн үр дүнд үйлдвэрлэлийн…….. болно. (2 оноо)
A. Үнэ ихэснэ, ашиг нэмэгдэнэ B. Үнэ буурна, зардал ихсэнэ
C. Зардал ихсэнэ, ашиг буурна D. Зардал буурна, ашиг нэмэгдэнэ
E. Зардал буурна, үнэ ихэснэ

38. Дэлгүүрт үхрийн махны үнэ өссөн учир Батаа хонины мах худалдан авсан бол зах зээл дээрх хандлага…………….. (2 оноо)
A. Орлуулах шинжтэй барааны эрэлт өсөх B. Хавсрах шинжтэй барааны эрэлт өсөх
C. Хонины мах гиффен бараа болох D. Үхрийн мах доорд бараа болох
E. Дээрх бүгд зөв

39. Монголд жирэмсэн болон сая төрсөн эхчүүдэд нийгмийн халамжийн ямар төрлийг үзүүлдэг вэ? (1 оноо)
A. Асрамжийн үйлчилгээ B. Халамжийн үйлчилгээ
C. Нийгмийн халамжийн тэтгэмж D. Нийгмийн халамжийн тэтгэвэр
E. Дээрх хариулт бүгд буруу

40. Дараах өгөгдлүүдээс аль нь соёлын нийлмэл элементэд орохгүй вэ? (1 оноо)
A. Зан үйл B. Ёс заншил
C. Уламжлал D. Албан хэм хэмжээ
E. Бүгд зөв

41. Ардчилсан улсад олон нийтийн байгууллагууд сайн дурын эвсэл холбоод олноороо байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулах нь чухал бөгөөд энэ нь……………боломж олгодог. (1 оноо)
A. Шинээр батлагдсан хуулийн талаар УИХ-аас мэдээлэл авах
B. Засгийн газарт санал тавих эрхтэй болдог
C. Олон улсын түвшинд бусад байгууллагуудтай эн тэнцүү харилцах
D. Өсч дэвших
E. Тухайн бүлгийнхэнд эрх нь зөрчигдсөн иргэд гишүүдээ өмгөөлөх хамгаалах

42. Ардчилал нь иргэддээ шашин шүтлэг, угсаа гарвал, нийгмийн байдлаас нь үл шалтгаалаад гарааны тэгш боломж олгох тухай номлодог. Хувь хүний авъяас, хичээл зүтгэл, нөр хөдөлмөр, шургуу байдал дээр тулгуурлаад тэгш бус байдал үүсч болох уу? (2 оноо)

A. Болно
B. Хэрвээ ийм байдал үүсвэл шударга ёс гэж байхгүй болно
C. Болохгүй
D. Бүх хүмүүс тэгш эрхтэй байх ёстой.
E. Аль нь ч биш

43. Хуйвалдаан ямар зах зээл дээр үүсэх боломжтой вэ? (1 оноо)
A. Төгс өрсөлдөөнт зах зээл
B. Монопольт өрсөлдөөнт зах зээл
C. Олигополь зах зээл
D. Монопользах зээл
E. Ямар ч зах зээл дээр үүсэхгүй

44. Эдийн засагт бүтээгдэхүүн үйлчилгээний үнэ өсч мөнгөний ханш ихээр унах үед төв банкнаас мөнгөний хумих бодлого эрчимтэй явуулахад эдийн засагт доорх өгөгдлүүдээс ямар хандлага гарч болох вэ? (3 оноо)
A. Ажлын байр ихсэнэ
B. Ажилгүйдэл ихсэнэ
C. Дефляци бий болно
D. Инфляци бий болно
E. Эдийн засгийн өсөлт бий болно.

45. Ямар соёлыг үндэсний, шашны, мэргэжлийн гэж ангилдаг вэ? (2 оноо)
A. Зонхилогч соёл
B. Сөрөг соёл
C. Дэд соёл
D. Аль нь ч биш
E. Ардын соёл

46. Соёл нь нийгмийн амьдралд тодорхойлогч үүргийг гүйцэтгэж түүний бүхэллэг шинж ба хөгжлийг нөхцөлдүүлж, нийгмийн амьдралын бүх хүрээ, түүний дотроос эдийн засгийн хүрээнд шийдвэрлэгч нөлөө үзүүлдэг гэдэг нь аль үзэл баримтлал болохыг тогтооно уу? (1 оноо)
A. Соёлын универсал байдлын тухай үзэл санаа
B. Марксист үзэл баримтлал
C. А ба В хариулт зөв
D. Зохицуулагч үүргийн тухай үзэл санаа
E. Аль нь ч биш

47. Эрх зүйн хэм хэмжээ, ёс суртахууны хэм хэмжээ, зан заншлын хэм хэмжээ зэрэг нь…………юм. (1 оноо)
A. Соёлын нийлмэл элемент
B. Соёлын хэм хэмжээний нийлбэр
C. Соёлын албан бус хэм хэмжээ
D. Соёлын универсал шинж
E. Соёлын давамгайлах элемент

48. Улс төрийн засаглал бүхэн төрийн засаглал байдаг. Харин төрийн засаглал бүхэн нь улс төрийн засаглал болж чаддаггүй. (1 оноо)
A. Тийм
B. Үгүй
C. Хуучин ЗХУ-ын эрдэмтэд ингэж үзэж байсан
D. Орчин үед ингэж үзэж байгаа
E. С ба D хариулт зөв

49. Хэрвээ 2006 онд мөнгөний ханш өссөн гэж үзвэл ҮНБ-ий хандлагыг тодорхойл. (3 оноо)
A. Бодит ҮНБ өссөн
B. Бодит ҮНБ буурсан
C. Нэрлэсэн ҮНБ буурсан
D. Нэрлэсэн ҮНБ буурсан
E. Дээрх бүгд буруу байна.

50. Таны бодлоор ажил эрхлэлтийн түвшин нь юунаас үл хамаарах вэ? (1 оноо)
A. Эдийн засгийн салбарууд дахь ажлын байрны өсөлт
B. Хүн амын тооны өсөлт
C. Ажиллах хүчний үнэ
D. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл
E. Хүн амын өвчлөл

51. Таны бодлоор ядуурлаас гарах арга замуудыг дурдахад хамгийн чухал асуудал аль нь вэ?
A. Цалин хөлсийг нэмэгдүүлэх
B. Зээл олгох, ажлын байр бий болгох
C. Нийгмийн хамгаалал хангамжийн тогтолцоог боловсронгуй болгох
D. Боловсрол мэргэжилтэй ажиллах хүчин бэлтгэх
E. Бүх иргэдэд эх орны хишгийг тараах

52. Орчин үед боловсролыг хэрхэн үзэж байна вэ? (1 оноо)
A. Хүн төрөлхтөн хойч үеэ сурган хүмүүжүүлэх
B. Хүмүүжигчид, хүмүүжүүлэгчээс нөлөөлөх нөлөөлөл
C. Хүн төрөлхтний бүтээсэн соёлын өвийг ахмад үеэс хойч үедээ дамжуулах үйл явц
D. Бие хүн төлөвших процесс, түүний үр дүн буюу бие хүний эзэмшсэн мэдлэг, чадвар, амьдрах ерөнхий арга чадварын цогц
E. Зөвхөн мэдлэг олгох процесс

53. Ерөнхий сайд ОХУ-п айлчлал хийх үеэр бизнесийн гэрээ хийжээ. Энд олон улсын харилцааны аль төрөл, хэлбэрийн тухай бичсэн байна вэ? (1 оноо)
A. Хоёр талт олон улсын харилцаа
B. Хоёр талт, эдийн засгийн харилцаа
C. Олон талт, эдийн засгийн харилцаа
D. Олон талт, улс төрийн харилцаа
E. Хоёр талт хүмүүнлэгийн харилцаа

54. 1945 оны 10 сарын 23-нд НҮБ анх ямар шалтгаанаар байгуулагдсан бэ?
   A. Бие даасан жлс орнуудыг сайн дурын үндсэн дээр нэгтгэж эдийн засаг, нийгмийн хөгжлийн таатай орчныг бүрдүүлэх, энх тайвныг сахин хамгаалахын төлөө
   B. Шинэ дайны аюулаас сэрэмжлэн хамгаалах, бүх нийтийн энх тайвныг сахин хамгаалах зорилготой
   C. Улс орнуудын эрүүл мэнд хүмүүнлэгийн салбарт тусламж үзүүлэх
   D. Тусгаар тогтносон улс орнуудад эдийн засгийн хөнгөлөлт үзүүлэх
   E. Дээрх хариулт бүгд зөв

55. Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг аль субъект нь тодорхойлох вэ? (1 оноо)
   A. УИХ
   B. Засгийн газар
   C. Нийгмийн хөдөлмөр хамгааллын яам
   D. Ерөнхийлөгч
   E. Улс төр

56. Үйлдвэрээс ирсэн үнэ дээр бүх зардал, олох ашгаа нэмж тооцоолсон үнийг………гэнэ. (1 оноо)
   A. Бөөний үнэ
   B. Үйлдвэрлэлийн үнэ
   C. Тэнцвэрт үнэ
   D. Нэрлэсэн үнэ
   E. Жижиглэнгийн үнэ

57. Дараах өгөгдлүүдээс аль нь соёлын хэм хэмжээний хэлбэрт орохгүй вэ? (1 оноо)
   A. Зан заншлын хэм хэмжээ
   B. Ёс суртахууны хэм хэмжээ
   C. Хууль зүйн хэм хэмжээ
   D. Эрх зүйн хэм хэмжээ
   E. Бүгд зөв

## ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1. Төрийн үүсэл гарлыг дараах эрдэмтэд өөрсдийн үзэл баримтлалын үүднээс харилцан адмлгүй тайлбарласан байдаг. Дараах өгөгдлүүдийг зөв харгалзуулна уу. (5 оноо)

| | | | |
|---|---|---|---|
| 1. | Шашны онол | A. | Классен, Фрейд |
| 2. | Эцгийн эрхт ёсны онол | B. | Августин, Аквинский |
| 3. | Нийгмийн гэрээний онол | C. | Аристотель, Фильмер |
| 4. | Нийгмийн эдийн засгийн онол | D. | Платон, Симон |
| 5. | Улс төрийн антропологийн онол | E. | Гроций, Спиноза |

2.2. Судалгааны боловсруулалтын аргуудын ойлголтыг тохируулна уу. (5 оноо)

| | | | |
|---|---|---|---|
| 1. | Анализийн арга | A. | Танин мэдэгдсэн нэгж, салангид хэсгүүдийг нэг зохицод оруулах сэргээн холбох дүгнэх |
| 2. | Синтезийн арга | B. | Тусгай тусгай юм үзэгдлүүд баримтаас ерөнхий үндэслэл гаргах |
| 3. | Индукцийн арга | C. | Хэд хэдэн нөхцлөөс гарсан баталгаа |
| 4. | Дедукцийн арга | D. | Бүхэл зүйлийг түүний бүрэлдэхүүн хэсэг нэгжид нь сэтгэхүйдээ салган хуваах арга |

2.3. Нийгмийн зарим институтын чиг үүргийг харгалзуул. (5 оноо)

| | | | |
|---|---|---|---|
| 1. | Гэр бүлийн | A. | Хоол хүнс, хувцас хэрэглэл, байр, орон сууцаар хангагдах |
| 2. | Эдийн засгийн | B. | Сүм хийдийн харилцаа дэг ёст үйлчлэх, шүтлэг бишрэлийг гүнзгийрүүлэх |
| 3. | Улс төрийн | C. | Хүүхдээ өсгөх, хүмүүжүүлэх, халамжлах |
| 4. | Шашны | D. | Хүмүүсийг нийгэмшүүлэх ба суурь үнэт зүйл, дадлага практикт суралцуулах |
| 5. | Боловсролын | E. | Хууль дүрэм ба хэм хэмжээнүүдийг дэмжих |

# 2010 оны Нийгмийн тухай мэдлэг хичээлийн даалгаврын түлхүүр

| № | Хувилбар A | Хувилбар B | Хувилбар C | Хувилбар D |
|---|---|---|---|---|
| 1 | C | B | D | B |
| 2 | C | A | D | B |
| 3 | B | D | A | B |
| 4 | B | E | A | D |
| 5 | B | B | D | B |
| 6 | E | C | E | A |
| 7 | A | B | C | C |
| 8 | D | C | A | A |
| 9 | B | A | C | A |
| 10 | E | A | D | D |
| 11 | B | B | B | D |
| 12 | C | C | B | D |
| 13 | B | B | B | A |
| 14 | C | A | E | B |
| 15 | A | C | B | C |
| 16 | D | B | C | A |
| 17 | D | B | B | B |
| 18 | B | D | A | D |
| 19 | A | E | A | B |
| 20 | B | D | B | A |
| 21 | B | A | A | B |
| 22 | D | B | D | C |
| 23 | D | B | D | D |
| 24 | D | E | B | B |
| 25 | B | C | B | A |
| 26 | A | D | E | A |
| 27 | B | B | A | A |
| 28 | A | D | C | A |
| 29 | D | E | B | A |
| 30 | C | A | D | A |
| 31 | B | A | B | B |
| 32 | B | C | A | D |
| 33 | A | E | A | B |
| 34 | A, D | E | A | D |
| 35 | D | E | D | C |
| 36 | D | C | A | D |
| 37 | D | A | A | D |
| 38 | A | C | A | A |
| 39 | B | A | A | C |
| 40 | B | C | C | D |
| 41 | D | B | B | E |
| 42 | E | E | C | A |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **43** | C | E | A | C |
| **44** | C | C | A | B |
| **45** | A | B | A | C |
| **46** | B | A | E | A |
| **47** | E | B | A | B |
| **48** | A | D | A | B |
| **49** | B | C | A | C |
| **50** | B | B | B | E |
| **51** | A | D | D | D |
| **52** | A | B | C | D |
| **53** | B | B | B | B |
| **54** | E | E | C | B |
| **55** | B | D | C | B |
| **56** | D | B | A | D |
| **57** | E | A | C | C |

| **Хоёрдугаар хэсэг** | | | | |
|---|---|---|---|---|
| **2.1** | 1-e | 1-c | 1-d | 1-c |
| | 2-c | 2-e | 2-c | 2-a |
| | 3-d | 3-d | 3-a | 3-e |
| | 4-a | 4-a | 4-b | 4-b |
| | 5-b | 5-d | 5-e | 5-d |
| **2.2** | 1-d | 1-c | 1-b | 1-d |
| | 2-e | 2-a | 2-a | 2-c |
| | 3-a | | 3-c | 3-b |
| | 4-c | 4-b | 4-e | 4-e |
| | 5-b | | 5-d | |
| **2.3** | 1-c | 1-b | 1-e | 1-c |
| | 2-a | 2-a | 2-a | 2-a |
| | 3-d | 3-d | 3-d | 3-e |
| | 4-b | 4-c | 4-c | 4-b |
| | | | 5-b | 5-d |